

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

2014 ОНЫ 12 САР. №20 (078)

ДАРААГИЙН ДУГААРТ



“MONGOLIAN ECONOMY”
СЭТГҮҮЛИЙН 2011-2014 ОНЫ
ШИЛДЭГ НИЙТЛЭЛҮҮД

www.mongolianeconomy.mn




БҮСЭЭ ЧАНГАЛАХ БҮРХЭГ ЖИЛ АЙСУЙ

ТӨСӨВ-2015
ЦООРХОЙ ТӨСӨВ

МӨНГӨНИЙ БОДЛОГО
ИНФЛЯЦИ БАС ДАХИН
ИНФЛЯЦИ

БАЯЛАГ БҮТЭЭГЧ
С.АМАРСАЙХАН:
МОНГОЛ УЛС ХҮЧИРХЭГ
ХУВИЙН ХЭВШИЛТЭЙ
БОЛНО ГЭДЭГТ
ЭРГЭЛЗДЭГГҮЙ



PC mall

BOSE
Better sound through research®

УТАСГҮЙ ТЕХНОЛОГИ


ШИНЭ ЖИЛЭЭР
ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮНТЭЙ



NEW

Bose® Soundlink®
Bluetooth чихэвч

 7575-3535

 Онлайн худалдаа:
www.pc-mall.mn

 Join us on Facebook
<http://www.facebook.com/PCmallOfficial>

МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ БАНК

*Бидний амжилтын хөтөч болсон эрхэм
харилцагч танд баярлалаа*

 **ГОЛОМТ БАНК**
Сайн сайхныг санхүүжүүлнэ

www.golomtbank.com



ШИЛДЭГ
БАНК
2011



ШИЛДЭГ
БАНК
2004, 2009, 2011, 2012



ШИЛДЭГ
БАНК
2012, 2013



ШИЛДЭГ
ИРГЭДИЙН БАНК
2014



ШИЛДЭГ
ИНТЕРНЭТ БАНК
2014



ШИЛДЭГ
ИНТЕРНЭТ БАНК
2013, 2014

Ногоон хөгжлийн тал

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:

Б.Үүрийнтуяа

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Ийланд Роберт Мэн

ВЭБ РЕДАКТОР:

Б.Энхцэцэг

ОРЧУУЛАГЧ:

Пүрэв-Очир

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

С.Батзаяа

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Баранжав / 9409 2904

Б.Наранцогт / 9409 2905

ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.

VI хороо, Их сургуулийн гудамж.

AV center. 504 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn

Борлуулах цэгүүд:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетийн бүх салбар

“Макс” супермаркетийн бүх салбар

“Фреско” супермаркет

BTSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр

“Max mall” дэх салбарууд

ТА 2015 ОНД МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ,
БИЗНЕСИЙН ТАЛААР ДҮН ШИНЖИЛГЭЭ БҮХИЙ
МЭДЭЭЛЭЛ ТОГТМОЛ АВМААР БАЙНА УУ?

ОНЛАЙН ЗАХИАЛГА
42% ХҮРТЭЛ
ХЯМДАРЛАА

Та <http://mongolianeconomy.imedia.mn>-руу орж
үнэгүй демо хараарай. Асуулт байвал бидэнд
7011-5476 утсаар хандана уу.

2012 Mongolian Economy. Developed by

ХЭМНЭЛТ
12-Р САРЫГ ДУУСТАЛ

16%
хэмнэнэ

1 ДУГААР 10,000₮

25%
хэмнэнэ

САНАЛ БОЛГОХ багц!

3 САР /6 ДУГААР/ 9,000₮

33%
хэмнэнэ

ИЛҮҮ САЙН багц!

6 САР /12 ДУГААР/ 8,000₮

42%
хэмнэнэ

ХАМГИЙН САЙН багц!

12 САР/24 ДУГААР/ 7,000₮

Монголын сэтгүүлдийн эвлэлийн “2013 оны Шилдэг сэтгүүл”

АГУУЛГА

ЭДИЙН ЗАСАГ

- 10 Ерөнхий сайдын “том” шийдвэр
- 12 Цоорхой төсөв
- 14 Зарцуулалтын задаргаа
- 17 Орлогогүй төсөв хөгжлийн зарлагагүй
- 18 Инфляци бас дахин инфляци
- 20 Инфляцийн чөдөр



**РЕДАКЦИД
ЗАХИАЛБАЛ
ХҮРГЭЛТ
ҮНЭГҮЙ**



- 22 Хувьчлалыг тандахад
- 25 Засгийн газрын үнэт цаасыг
яагаад худалдан авах хэрэгтэй вэ?
- 26 Австрали элч
- 28 Тулгын гурван чулууны загвар
- 33 “Чингис” бондын зарцуулалт
- 34 С.Амарсайхан:
Монгол Улс хүчирхэг хувийн хэвшилтэй болно
гэдэгт эргэлздэггүй
- 39 Алтан үе



facebook.com/Mongolian.
Economy



twitter.com/
EconomyMongolia



youtube.com/user/
MongolianEconomy

Шинэ iMac

Гүйцэтгэл болон дизайны хамгийн зөв зохицол.



iMac
with Retina 5K display



БҮРТГЭЛ

www.INVESTHUBMONGOLIA.com

Look Mongolia оффис, 3 дугаар давхар
Чингисийн өргөн чөлөө 98, Улаанбаатар 17032

Утас: 976-344488, 976-99105877

И-мэйл: info@investhubmongolia.com









InvestHUB MONGOLIA 2015

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮҮР
ОЛОН УЛСЫН ЧУУЛАГА УУЛЗААЛТ

ТӨСӨЛ ТАНИЛЦУУЛАХ | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖУУД | ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ

Салбарууд

-  Уул уурхай, хүнд үйлдвэрлэл
-  Барилга бүтээн байгуулалт
-  Эрчим хүч
-  Хүнс, хөдөө аж ахуй
-  Боловсруулалт, хөнгөн үйлдвэрлэл
-  Аялал жуулчлал, зочлох үйлчилгээ

14 - 15

Нэгдүгээр сар

2015

The Corporate Hotel & Convention Center
Ulaanbaatar, Mongolia

Зохион байгуулагч болон хамтран зохион байгуулагчид

Майнэкс Монгол ХХК | Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны яам
Хөрөнгө оруулалтын газар | Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам | Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам
Уул уурхай, эрчим хүчний яам | Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
Монголын бизнесийн зөвлөл | Тианжины олон улсын уул уурхайн бирж | AmCham

Албан ёсны мэдээллийн
ИВЭЭН ТЭТГЭГЧ

Forbes
MONGOLIA
ECONOMY

МОНГОЛД

Орон сууц



Нийслэлийн хэмжээнд өнгөрсөн жилүүдэд “Иргэдийг орон сууцжуулах хөтөлбөр”-үүд нэлээдгүй идэвхжиж төрөөс нийлүүлэлтийг дэмжсэн бодлого явуулж ирсэн. Тухайлбал, өнгөрсөн онд орон сууц шинээр олгоход 582.8 тэрбум, орон сууцны зээлийг дахин санхүүжүүлэхэд 872.1, барилгын гол нэр төрлийн материалын үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөрт 296.1 тэрбум төгрөгийг Монголбанкнаас, орон сууцны барилгын нийлүүлэлт нэмэгдүүлэхэд 429.5, гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх, газар чөлөөлөхөд 70 тэрбум төгрөгийг Засгийн газраас зарцуулжээ.

Өнгөрсөн онд нийт 16500 орчим айлын орон сууц ашиглалтад орж арилжааны банкнаас нийт 14685 иргэн орон сууцны зээл авсан аж. Түүнчлэн орон сууцны үнэ 26 хувиар өссөн байна.

Аялал жуулчлал



Манай улс аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индекс төгөрсөн онд 99 дүгээр байранд эрэмблэгдсэн бол 2017 онд 90 байранд, 2020

онд 80 дугаар байранд жагсах зорилт Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас дэвшүүлжээ. Энэ хүрээнд ирэх онд зохиогдох олон улсын аялал жуулчлалын “ITB Berlin-2015” үзэсгэлэнд түнш орноор оролцох юм. Уг үзэсгэлэнд оролцдог орнуудад ирэх жуулчдын тоо 20-30 хувь нэмэгддэг гэх судалгаа байдаг аж. Энэ хэмжээгээр аялал жуулчлалын салбараас Монгол Улсын эдийн засагт оруулах хувь нэмэр сайжрах боломж бий гэдгийг салбарынхан хэлж буй. Жил бүр дэлхийн 120 гаруй орны 100 мянга гаруй үйлчлүүлэгч ирдэг тус үзэсгэлэнд оролцсоноор тухайн улсын гадаад сурталчилгааны дүр төрхийг бүрдүүлэх, цаашлаад аялал жуулчлал, соёл урлаг, зам тээвэр, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ зэрэг олон салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулах ач холбогдолтой аж.

Эдийн засаг

Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан Монголын хөрөнгийн бирж энэ оны наймдугаар сарын 4-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа хэмнэлт хийж эхэлжээ. Энэ хүрээнд байгууллагын дотоод зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чиг үүргийн давхардлыг арилгах, тэргүүн дэд захирал, дэд захирал болон тэдгээрт үйлчлэх жолоочоос гадна зарим ажлын байрыг цомхотгож, томоохон худалдан авалтыг зогсоох зэргээр бүх түвшинд зардалаа танах арга хэмжээ авсаны дүнд нийт зардлаа 23 хувиар бууруулж чаджээ. Ингэснээр тус компани ирэх сарын 1-ний өдрөөс санхүүгийн хэвийн горимд шилжих боломж бүрджээ. Түүнчлэн дотоодын болон гадаадын аливаа аж ахуйн

нэгжид хугацаа хэтэрсэн өр төлбөргүй болсон байна. Биржийн ажилтнууд өөрсдийн санаачилгаар цалингаа 30 хувиар бууруулах шийдвэрийг гаргасан нь хэмнэлт амжилттай хэрэгжих үндэс болсон аж. Мөн өнгөрсөн хугацаанд Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтын ажиллагаагаа гурван жилээр сунгасан, Засгийн газрын үнэт цаасны арилжааг дахин сэргээсэн, хяналт, бүртгэл болон гишүүнчлэлийн цогц журмуудыг шинэчлэн Санхүүгийн зохицуулах хороогоор батлуулсан зэрэг томоохон ажлыг хийж гүйцэтгэжээ.

Даатгал



Манай улсын даатгалын компаниуд эрсдэлээ гаднын компаниудад давхар даатгуулдаг. Энэ оны гуравдугаар улирлын байдлаар нийт 23 тэрбум төгрөг гадагш төлөгдсөн байна. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль энэ онд батлагдсантай холбоотойгоор хөдөө аж ахуйн давхар даатгалын анхны компани байгуулагдах гэж байна. Жил бүр давхар даатгалд төлдөг хураамжийн хэмжээ нэмэгдсээр байгаа нь валютын урсгал гадагш чиглэх үндэс болж байгааг Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга П.Цэрэндэжид хэлж буй. Даатгалын компанийн чадавхыг нэмэгдүүлэх, мөнгөний гадагш урсгалыг

тодорхой хэмжээнд барих үүднээс “Үндэсний давхар даатгалын компани” байгуулах ажил хэрэгжиж эхлээд байгаа юм. Тус компани байгуулагдсанаар эдийн засаг болоод дотоодын даатгалын салбарын хөгжилд бодитой үр дүн гарна гэдгийг мэргэжилтнүүд хэлж байна.

ДЭЛХИЙ ДАХИНД

Рио Тинто

“Форчун” сэтгүүлээс энэ онд гаргасан “Форчун Глобал 500” жагсаалтын 10 дугаарт бичигдсэн Англи-Швейцарын уул уурхайн компани Гленкор Рио Тинто Группээс худалдан авалт хийхээр төлөвлөж байна хэмээн Блүүмберг мэдээлжээ. Гленкор уул уурхайн томоохон “Экстрата” компанийг 29 тэрбум ам.доллараар өнгөрсөн онд худалдан авсан бөгөөд өдгөө Рио Тинтогийн худалдаж авахаас татгалзсан 160 тэрбум ам.долларын худалдан авалтыг хийх сонирхлоо илэрхийлээд буй юм. Тус компани Рио Тинтогийн хэд хэдэн хөрөнгийн арилжаанд оролцох хүсэлтэй байгаа аж. Үүнд Монголын “Оюутолгой” төсөл орж буй юм. Хэдэн тэрбумаар яригдах “Оюутолгой”-н II шатны хөрөнгө оруулалт улс төрийн болоод бусад асуудлаас үүдэж цаашдын хөгжил нь зогссонги байгаа учир Рио Тинто энэ уурхайг богино хугацаанд эргэлтэд оруулах боломжит худалдан авагч хайж байгаа аж. Рио Тинтогийн хамгийн том хувьцаа эзэмшигч / ойролцоогоор 10 хувь/ Хятадын төрийн эзэмшлийн хөнгөн цагааны Чиналко компани хамгийн бэлэн байгаа худалдан авагч

болоод байна.

Хятад-Австралийн чөлөөт худалдааны гэрээ

Хятад Австрали улсын хооронд 10 жил үргэлжилсэн 22 удаагийн хэлэлцээрийн дараа хоёр орны хоорондын Чөлөөт худалдааны гэрээний хандлагын тунхагт гарын үсэг зурлаа. Хятадын Ерөнхийлөгч Си Зинпин Австралид айлчлах үеэр энэ явдал болсон юм. Үүгээр Хятад улс Австралийн цагаан идээ, үхрийн мах, хонь болон дарсанд тавьсан хоригийг цуцлах аж. Мөн энэ хүрээнд коксжих нүүрсний тариф шууд цуцлагдах бол хүрэн нүүрсэнд тавьсан тарифыг хоёр жилд багтаан цуцлахаар боллоо. Ойрын 10 жилийн хугацаанд зэс, алт, газрын тос ба төмрийн хүдрийг оролцуулаад Хятадад орох Австралийн экспортын 95 хувь нь тарифгүй байхаар болжээ.

Путин Энэтхэгт айлчилна

Украины хямралтай холбоотойгоор ОХУ-д тавиад байгаа барууны орнуудын эдийн засгийн хоригуудыг давахын тулд ОХУ-ын Ерөнхийлөгч Путин Энэтхэгт улсад энэ сард айлчилна. ОХУ эрчим хүчний экспортоо төрөлжүүлж улмаар Энэтхэгт хийх газрын тос ба хийн хоолойгоо тэлэх сонирхолтой байгаа. ОХУ, Энэтхэг нь худалдаа болон стратегийн түншлэлийн олон жилийн түүхтэй бөгөөд шинээр сонгогдсон Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Модич тус улстай илүү хүчтэй эдийн засгийн харилцаа явуулахыг чармайж байгаа аж. Хятад руу тавигдах Газпромын 400 тэрбум ам.долларын эрчим хүчний бизнес эхэлсний дараа Энэтхэгийн зах зээл рүү орох юм. ■



МОНГОЛ ЖИРГЭЭНИЙ ЕРТӨНЦӨД

Thomas Eriksson @ThomasE_UNDP Nov 28

Миний дэлхий 2015 санал асуулгад зөвхөн 528 хүн оролцсоны ихэнх нь боловсрол, эрүүл мэнд ба шударга засгийн газар чухал гэжээ.

Илүү Сайн Дэлхийн төлөө НҮБ-ын судалгаа-Миний Дэлхий 2015 хүмүүсийн амьдралд чухал 6 асуудлыг хөндөж байна. Энэ нь хүмүүс олон нийтэд өөрийн санаа бодлоо хүргэх бас илүү сайн дэлхийн талаар санаа бодлоо хуваалцах шууд арга юм.

UNESCO @UNESCO . 27/11

Монгол улс биет бус өвөө бүртгүүлжээ.

Монголын шагайн харваа нь Юнеско-ийн Биет Бус Соёлын Өвийн Жагсаалтад оржээ. Шагайн харваа нь гартаа барьсан гулсамтгай гадаргуунаас хавтгай биетээр шагайг харвах багын тоглоом ажээ.

Jargalsaikhan @SJJargalsaikhan, 28/11

9 тэрбум ам. долларын ногоон цаг уурын фондод Монгол улс нэгджээ.

[#GreenClimateFundhttp://www.rtcc.org/2014](http://www.rtcc.org/2014)

2020 он гэхэд 100 тэрбум долларыг босгох НҮБ-ын Цаг Уурын Өөрчлөлтийн Конвенцийн Ногоон Уур Амьсгал Фондод Монгол Улс 50 000 ам. Доллар хандивлажээ. Энэ фонд нь хөгжиж байгаа орнуудад цаг агаарын өөрчлөлтийн эсрэг хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр ба бодлогуудыг дэмжих зориулалалтай аж.

@UNFPA_Mongolia 19/11

[#Rightnow](#), Монголын төлөөлөгчид Бангкок нэгдэнэ.

НҮБ-ын Хөгжлийн Сан Тайландын Бангкок хотод болох хуралд нэгдсэн ба энд Ази, номхон далайн бүсийн сэтгүүлчид, иргэний нийгэм болон засгийн газрын төлөөлөгчид чуулж бус нутгийн жендерийн тогтвортой байдлын талаар ярилцах юм. Хэд хэдэн сэтгүүлч, иргэний нийгмийн болон засгийн газрын төлөөлөл уг арга хэмжээнд оролцоно.

Schattendoppelganger @Erdembayar,

Энэ үйлдвэр жилд 1600 км төмөр замын рэйс үйлдвэрлэх хүчин чадалтай, өөрсдөө хямд төмөрзам тавих чадалтай боллоо гэсэн үг [#БэрэнМетал](#)

Эх орондоо төмрийн хүдэр боловсруулах үйлдвэртэй болж дотоодын хэрэгцээгээ хангаж эхэлжээ. Дотоодын хүчээр төмөр зам тавих боломж бүрдэж буй эхний алхам тавигджээ.

Duuren T @TDuuren Dec 1

За ингэж уулздын байжээ хэмээн зэсийн үнэ долларын ханшид хэлэв.

[#уруудаж](#) өсөж яваа хоёр

БНХАУ-ын зах зээл дээрх зэсийн дундаж үнэ энэ оны аравдугаар сарын байдлаар 6738 төгрөгт хүрсэн байна. Энэ нь өнгөрөгч есдүгээр сарын дундаж үнэтэй харьцуулбал 1.94 хувиар буурсан үзүүлэлт юм. Харин ам.долларын ханш чангарч 1895 төгрөгт хүрсэн байна. Нэг нь буурч нөгөө нь өссөнөөр нэг цэгт хүрч буй.



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

АН-ын ҮЗХ-ны хурлын дараа

ЦАГ ҮЕ

ЕРӨНХИЙ САЙДЫН “ТОМ” ШИЙДВЭР

С.ЗАЯА

Монгол Улсын 28 дахь Ерөнхий сайдаар Чимидийн Сайханбилэг томилогдсон нь хэдийнэ хуучирсан мэдээлэл болоод байна. Тэр ажлаа аваад хоёр долоо хоног орчим болж буй ч өнөө хэр нь кабинетаа бүрдүүлж амжаагүй байх. Сайдын суудал горилогчдын нэрс эхнээсээ тодорч, саарал ордонд аль нам, фракцаас гаргасан нь үл мэдэгдэх “бор шувуунууд” ниссээр. Нэгэнт гүйцэтгэх засаглалын Тэргүүн тодорсон учир кабинетаа бүрдүүлээд явах нь хэнд ч ойлгомжтой байгаа. Гагцхүү үүнд цаг хугацааны асуудал буй юм.

Харин “Mongolian Economy” сэтгүүл энэ удаа улс төрийн халуун үйл явдал, сандал ширээний хэрүүлийг хойш тавин шинэ Засгийн газрын тэргүүний цаашид авч хэрэгжүүлэх бодлогод үнэлэлт дүгнэлт өгөхийг чухалчилж буйгаа нийтлэлийнхээ эхэнд тодотгох

нь зүйтэй байх. Ч.Сайханбилэг УИХ-аас томилогдонгуутаа цаашид хэрхэн ажиллах талаараа хэлсэн үгэндээ нэгдүгээрт эдийн засаг, хоёрдугаарт эдийн засаг, гуравдугаарт эдийн засаг гэсэн нь элгээрээ мөлхөөд буй Монголын эдийн засагт амь тариа залгах нь гэсэн хүлээлтийг нийгэмд бий болголоо. Энэ талаар тэрбээр “Эдийн засгийн чухал асуудлуудыг штабын маягийн зохион байгуулалт, хурдаар шийдэх учиртай. Шинэ Засгийн газарт цаг хугацааны “Аль болох хурдан” гэдэг ганцхан хэмжээс үйлчлэх болно. Ерөнхий сайдын зүгээс өдөр тутмын салбарын асуудлуудын эрх мэдлийг сайд нарт бүрэн шилжүүлж зөвхөн эдийн засагт гол анхаарлаа хандуулна. Иймд Сайд болгон салбартаа Ерөнхий сайд нь байх учиртай” хэмээсэн.

Тэр Монгол Улс хямралтай байгааг хүлээн зөвшөөрлөө. Тэгэхээр цаашид ямар бодлого барьж, хямралаас гарах гэж буй нь сонирхол татаж байна. Нэн

түрүүнд хоёр үе шаттай арга хэмжээ авахаар зэхсэн нь зөв ч бас буруутгах зүйл байх. Урт болон дунд хугацаанд багагүй ажил хийхээр төлөвлөжээ. Нэн түрүүнд эдийн засгаа системээр нь нэг оношлох аж. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн хангалттай нөөцтэй, менежментийн зөв тогтолцоотой, эрсдэлийн шуурхай удирдлагатай эдийн засгийг бий болгох юм. Ингэхдээ эдийн засгаа солонгоруулах бодлогоо ажил хэрэг болгож, эхний ээлжинд аялал жуулчлал, мэдээллийн технологи, ХАА тэр дундаа мах, ноолуурын салбараа уул уурхайтайгаа зэрэгцүүлэхээр тооцжээ.

Энэ үнэхээр сайн хэрэг. Уул уурхайн мөчлөг дагасан эдийн засагтай учраас Монголд хямрал нүүрлэж байна гэж судлаачид байнга ярьсаар ирсэн. Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн Санхүүгийн удирдлагын тэнхмийн багш, эдийн засагч Ж.Дэлгэрсайхан “Монгол Улсыг хөгжүүлэх суурь бодлогоо тодорхойлж байж “Чингис”, ▶

▶ “Самурай” болоод бусад бондын хөрөнгийг зарцуулсан бол одоогийн ийм нөхцөл байдалд хүрэхгүй байлаа. Тиймээс цаашид бид одоо батлаад байгаа бодлогын баримт бичгүүдээ маш цэгцтэй хоорондоо уялдаатай болгож, уул уурхай, аж үйлдвэр, хөдөө аж ахуйгаа хөгжүүлэх ёстой. Ингэж байж Монгол Улс цаашид яаж хөгжих юм бэ гэсэн алсын хараатай бодлого гарч ирнэ. Үүний дараа нэн түрүүнд алийг нь хөгжүүлэх вэ гэдгээ ярилцах хэрэгтэй” гэж байв. Урт хугацаандаа барих бодлогодоо маш няхуур хандахаар төлөвлөсөн нь цаасан дээр бус амьдрал дээр хэрэгжвэл нүдээ олсон шийдвэр болох нь дамжиггүй юм.

Ам.долларын ханш 1900 гарч, төгрөгийн ханш суларч, иргэдийн худалдан авах чадвар муудсан энэ үед “Монгол Улс маань хямралаас хэзээ салах бол” гэсэн бодол хүн бүрийн толгойд эргэлдэнэ. Тэгвэл түүний Засгийн газар ойрын хугацаанд өмнөх кабинетын хэрэгжүүлж байсан “Эдийн засгийг идэвхижүүлэх 100 хоног”-ийн хүрээнд хийхээр төлөвлөж байсан ажлуудыг цааш үргэлжлүүлэх нь. Юуны өмнө Хөрөнгө оруулалт, Хөнгөлөлттэй зээл хоёрын зөв хослол дээр суурилсан өрийн удирдлагын шинэ тогтолцоог бий болгохор төлөвлөсөн байна.

Өрийн босгыг нэмэгдүүлэх нь хямралаас гарах загвар мөн үү

“Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний цогц төлөвлөгөө”-г боловсруулах аж. Энэ хүрээнд төсвийн зохистой бодлого болон өрийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, макро эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангах арга хэмжээг тусгахаар болжээ. Учир нь манайд өнөө маргаашгүй бэлэн мөнгөний шинэ урсгал яаралтай бий болгох шаардлага бий гэж тэр үзэж. Өрийн асуудалд бид болгоомжтой хандах ёстой. Өнгөрсөн онуудад авсан зээлийн төлөх хугацаа хаяанд ирчихээд байхад хэрхэн төлөх нь тодорхойгүй байгаа. Ийм үед дахин их хэмжээний зээл авах нь хэр оновчтой бол. Энэ талаар Сангийн дэд сайд асан Ч.Ганхуяг “Зээл авч болно. Гэхдээ Оюутолгойг эргэлтэд оруулж, төмөр замаа шийдсэн байх ёстой. Монголбанк улстөрөөс хараат бус байж, мөнгөний

бодлогоо дангаараа хэрэгжүүлэх хэрэгтэй. Ханш тогтворжсон байх ёстой. Учир нь бид өнөөдөр зээл нэмж авахгүй байж илүү өрөнд орж буй юм шиг харагдаж байна. Валютын ханшийн өөрчлөлтөөс болоод улсын өр ДНБ-ий 60-аас дээш хувьд хүрсэн. Энэ асуудлуудыг шийдэхгүйгээр нэмж өр тавьж болохгүй” гэв.

Харин Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “БНХАУ-ын дарга Си Зинпиний Монгол Улсад айлчлахдаа амласан нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийг авч эргэлтэд оруулах ёстой. Бид цаашид алдаан дээрээсээ суралцан 30,40 жилийн дараа төлөх, бага хүүтэй, урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр зам, төмөр зам болон дэд бүтцийн удаан хугацаанд үр ашгаа нөхөх төслүүдийг санхүүжүүлэх. Харин бондын богино хугацаатай, хүү харьцангуй өндөр зээлээр үйлдвэрийн төслүүдээ санхүүжүүлж байх зарчимд шилжицгээе. Дээрх хөнгөлөлттэй зээлийг авснаар зам болон төмөр зам руу хийсэн “Чингис” бондын хөрөнгөө суллаж авах бололцоотой болох юм” гэсэн.

Баялаг бүтээгчдийг дэмжинэ

Суларсан бондын мөнгөө хувийн хэвшлийнхэнд зориулсан Хөрөнгө оруулалтын баталгааны сан байгуулах, үр ашиг бүхий экспортыг дэмжсэн, импортыг орлосон үйлдвэрийн төслүүдийг санхүүжүүлэх аж. Ингэж байж 2017 онд төлөх бондын төлбөр хийх бэлтгэлээ хангана гэж Ерөнхий сайд үзжээ. Гэхдээ дээрх ажлуудыг хийхэд урд хөршөөс орж ирэх их мөнгө томоохон нөлөө үзүүлэх нь тодорхой байгаа учир энэ асуудалд хэрхэн хандахаас бүх зүйл шалтгаалахаар байна.

Хувийн хэвшлээ дэмжиж, бизнесээ тэлсэн бодлогоор хямралаас гарна гэж үзсэн түүний бодлогыг олзуурхах хүн олон. Монгол Улсыг баялаг бүтээгчид буюу хувийн хэвшлийнхэн авч явж буй гэвэл дэгсдүүлсэн болохгүй биз ээ. Тэрбээр бизнесийн орчинг ээлтэй болгох бодлогоо эрчимжүүлж, тусгай зөвшөөрөл лицензийн хуулиа баталж, бизнесийнхэнд үзүүлж буй хууль хяналтын байгууллагууд, татвар гаалийнхны дарамтыг хөнгөлөхөөр шуурхай ажиллахаа хэлсэн. Энэ хүрээнд Эдийн засгийн ил тод байдлын тухай

хуулийг баталж, бизнес эрхлэгчдэд өршөөл үзүүлэх юм байна.

2008-2009 оны санхүүгийн хямралын үед бусад оронд үр дүнтэй хэрэглэсэн “bail out”-ын аргыг одоо бид хэрэглэх цаг болсон гэж Ерөнхий сайд хэллээ. Компаниуд банкнаас нэмж зээл авах, барьцаалах хөрөнгө үндсэндээ байхгүй болж, авлага өглөгийн асар том сүлжээ үүсээд байгаа аж. Иймд компанийн хувьцаа, өөрийн үнэлгээг барьцаалан зээлжих шинэ бололцоог нээж өгөх нь.

Үүнээс гадна нүүрснээс хий, шингэн гаргах, хос төмөр зам, “Талын зам” зэрэг томоохон төслөө урагшлуулж, ирэх жилд 900-1200 мВт хүчин чадал бүхий цахилгаан станцын хоёр төслийг эхлүүлэх аж. Монгол руу хөрөнгө оруулах сонирхол бүхий 180 компаниас авсан судалгаагаар 140 нь Оюутолгой, Тавантолгойн асуудал хэрхэн шийдэгдэхээс тэдний шийдвэр шалтгаална гэж хариулжээ. Тиймээс энэ хоёр төслөө хэрхэн “хөдөлгөх” вэ гэдгээ шинэ Засгийн газар удахгүй УИХ-д танилцуулах аж. Энэ талаар Ерөнхий сайд “Бид олон жил Оюутолгой, Тавантолгой гэж ярилаа. Одоо ядаж 2-3 стратегийн орд газруудыг нэмж хөдөлгөх цаг болсон. Ингэж байж л Баялгийн сан зохих хөрөнгөтэй болно, монгол хүн бүрийн гар дээр байгаа хувьцаа үнэтэй утгатай болно” хэмээсэн.

Шийдлийн Засгийн газар эдийн засгаа сайжруулахаар олон ажлыг дэс дараатай хийхээ ийн мэдэгдлээ. Мэдээж хэдхэн сарын дотор өргөс авсан мэт бүх зүйл сайжрахгүй. Түүний кабинетийн гаргасан шийдэл, шийдвэр нүдээ олж гэмээнэ хууль тогтоох байгууллага алхаа цохино. Монгол Улс маань гуравхан сая хүн амтай, 10-хан тэрбум ам.долларын эдийн засагтай. Бодлогын зөв өөрчлөлт, гацсан ганц хоёр асуудлыг байрнаас нь хөдөлгөж, дэмжиж, урагшлуулсан 2, 3-хан том төсөл бидний хямралт байдлыг эрс өөрчилнө гэж тэр хэлнэ лээ. Үнэхээр ч тийм. Гэхдээ үүний хэд нь биелэх нь цаг хугацаа, түүний удирдах арга барил, ур ухаан, зөв бодлого, менежментээс ихээхэн хамаарна. Хонх нь дуугарахаар дамар нь таг, дамар нь дуугарахаар хонх нь таг, хоёулаа дуугарахаар лам нь таг гэгч болохгүйн тулд Тэр хичээх ёстой. Хичээхээс ч өөр аргагүй зам түүний өмнө дуниартан байна. ■

ТӨСӨВ-2015



ЦООРХОЙ ТӨСӨВ

С.БАТЗАЯА

Монгол Улсыг нэг өрх айл гэж авч үзвэл ирэх онд орлого багатай, зарлага ихтэй байх нь. Гэхдээ бага зарлага гаргахын тулд тэвчиж болох бүхий л зардлыг хэмнэж урд хормойгоороо хойд хормойгоо нөхөх болчихоод байна. Тухайлбал, ирэх жил төрийн албан хаагчдын тоог нэмэхгүй /шинээр ашиглалтад орох сургууль, цэцэрлэгийн орон тооноос бусад/ харин ч бууруулна. Ингэхдээ дэд, орлогч, зөвлөх гэх шинээр үүссэн орон тоонд 345 хүнийг цомхотгосноор гурван тэрбум, төрийн байгууллагын 540 орон тоог бууруулснаар дөрвөн тэрбум, бараа ажил үйлчилгээний зардлыг 32 тэрбум төгрөгөөр бууруулахаар тооцоод буй.

Одоо 13 хувьтай байгаа инфляцийг ирэх оны эцэс гэхэд долоо, эдийн засгийн өсөлтийг мөн хувьд барихаар 2015 оны төсөвт тусгажээ. Сүүлийн дөрвөн жилийн хугацаанд ийм хэмжээний буурсан төсөв баталж байсангүй. Мөн улс төрийн нөхцөл байдлын хувьд Засгийн газар огцорсон, Сангийн сайдгүй хүнд үе

таарлаа хэмээн хууль тогтоогчид сайшааж ярих 2015 оны төсвийг манай сэтгүүл олон талын байр суурийг тусган хөндөж байгаа юм.

Төсөв батлаад хагас сар гаруйн хугацаа өнгөрч байхад хуучирч ужгирсан сэдэв хөндөж байна гэж уншигч Та бүү бодоорой. Үнэхээр чамбай төсөв болж чадсан эсэхийг улстөрчдийн хүрээнд бус мэргэжлийн эдийн засагч, судлаачдын байр суурийг сонсон, тодотгол хийхдээ юунд анхаарах ёстойг сэтгүүлийн хуудсаараа дамжуулан хүргэхийг зорилоо.

Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогыг 7.159.9 тэрбум төгрөг буюу 29.8 хувь байхаар төсөвт тусгаж. Тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн нэгдсэн төсвийн нийт зарлага 7.599.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.7 хувь, алдагдал 439.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.8 хувь байхаар батлаад байна. Энэ жилийн төсвөөс ирэх оны төсөв 4.1 хувиар нэмэгдсэн. Үүнийг 2013 оны жилийн эцэстэй харьцуулахад 20,2 хувийн өсөлттэй гэсэн үг. Харин нийт зардлаар нь авч үзвэл мөн хугацаанд 23.3 хувийн өсөлттэй байна. Энэ оны төсвийн гүйцэтгэлийг харахад анх батлагдсан төсвийнхөө түвшинд очиж чадахааргүй болчихоод буй. Ерөнхийдөө өнгөрсөн

оны эцэстэй харьцуулахад өсөлт төдийлэн алга байхаар байна. Зарлага нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хязгаартай адил байх нь. Энэ талаар Азийн хөгжлийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газрын эдийн засагч Л.Амар “Орлогоор зарлага хязгаарлагддаг. Энэ онд хүлээгдэж буй орлого өнгөрсөн жилийн түвшинд байхаар байна гэж харж байгаа. Иймд ирэх оны төсөвт орлогыг энэ жилийн гүйцэтгэлээс 20 орчим хувийн өсөлттэй байхаар тооцсон байна лээ. Ийм өсөлт бий болоход нэлээд төвөгтэй. Эдийн засгийн өсөлт удааширч байна. Томоохон төслүүд ирэх оны эхээр шийдэгдээд хөрөнгө оруулалт нь орж ирвэл эдийн засгийн өсөлт 7.5 хувьтай болно гэж харж байсан. Гэтэл улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдлөө. Энэ өөрчлөлт нь хэр удаан үргэлжлэх үү, томоохон төслүүдэд ямар нөлөө үзүүлэх вэ гэдгээс хамаарч ирэх оны төсвийг хэлэхэд тодорхойгүй байдал үүсч байгаа юм” гэв.

2015 оны төсөв өмнөх жилүүдийнхээс онцлогтой байсныг дурьдах нь зүйтэй. Учир нь ирэх онд орлогын түвшинг харьцангуй бодитой тооцох гэж оролдож, тодорхой хэмжээнд хэмнэх гэж хичээсэн. Гэхдээ урсгал зардлыг танах дээр зохицуулалт, хяналтыг сайн хийж чадсангүй. Тэгсэн хэр нь хөрөнгө оруулалтын зардлыг их хэмжээгээр танажээ. Энэ талаар Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн Санхүүгийн удирдлагын тэнхмийн багш, эдийн засагч Ж.Дэлгэрсайхан “Өмнөх жилүүдийн хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлж, шинээр энэ чиглэлд санхүүжилт бараг төсөвлөсөнгүй. ➤

Хэдийгээр урд жилүүдийг бодвол орлогыг бодитоор төсөөлсөн ч хөрөнгө оруулалт хийх ёстой зарим ажлыг тойргийн гадна үлдээлээ. Ялангуяа боловсрол, эрүүл мэндийн салбарт хийх ёстой төсвийг танах ёсгүй байсан. Төрийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн үндсэн эх үүсвэр бол төсөв. Тиймээс боловсролын салбарын төсвийг хассан нь сайн зүйл биш. Учир нь сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол Монгол Улсын ирээдүйг төлөөлж буй гэсэн үг юм. Хүүхэд багачуудын боловсрол чанартай, түүнийг эзэмших орчин тав тухтай байвал манай улс хөгжинө. Агаарын бохирдлыг бууруулах зэрэг санд өгөх төсвийг танасан нь зөв хэмээсэн.

Хууль тогтоогчид боловсрол, эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг хасаагүй гэх боловч анагаахын эрдэм шинжилгээний байгууллага, эрүүл мэндийн томоохон төвүүдийн зардлыг 2-3 тэрбум төгрөгөөр танажээ. Энэ талаар Нээлттэй нийгэм форум байгууллагын судлаачид судалгаа хийсэн байна. Хамгийн наад захын жишээ дурьдахад, МСҮТ-үүдийн төсвийг хэдэн зуун саяар бууруулж. Монгол Улс үйлдвэрлэлийг дэмжинэ, мэргэжилтэй ажиллах хүч хэрэгтэй гэж ярьдаг атлаа төсвийг нь ийн танасан нь учир дутагдалтай гэж тэд үзэж байна.

Уул уурхайн салбараас ихийг хүлээх хэрэггүй

Нүүрсний экспорт өмнөх жилүүдтэй харьцуулахад 20 сая тонн гэдэг боломжийн тоо. Энэ бодит байдал нэлээд дөхөж очсон тооцоолол гэж үзэж болох. Тухайлбал, энэ жил 31.4 сая тонн нүүрс экспортолно гэж төлөвлөөд жилийн эцэст 10 гаруйхан сая тонн байх төлөв бий. Энэ нь төсөвт маш хүчтэй нөлөөлж, улс орны бодлогын хэрэгжилтэд ч саад тотгор болж буй. Үүнээс гадна ирэх оны төсөвт нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг нэлээд өндрөөр тооцожээ. /тонн нүүрс 80-130 ам.доллар/ Гэтэл тэр үнээр өнөөдөр бид нүүрсээ экспортолж чаддаггүй.

Ирэх жил экспортлох нүүрснээсээ 217.2 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлэх зорилт тавьсан

байна. Улсын экспортын ашгийн дийлэнхийг бүрдүүлдэг нүүрсний салбарын зорилтыг ийнхүү багаар төсөөлөх болсон нь сайшаалтай ч үнийн хувьд бодит байдалтай дүйж очиж чадсангүй. Одоо нэг тонн нүүрсийг 35-50 ам.доллараар худалдаж буй юм.

Бусад уул уурхайн бүтээгдэхүүний тухайд, таван сая тонн төмрийн хүдэр экспортолж 97.3, 1.409.2 мянган тонн зэсийн баяжмал экспортолж 620, 10 мянган тонн алт экспортолж 121.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр ирэх оны төсөвт тусгажээ. Энэ бүгдийг багцлаад уул уурхайн салбараас ирэх онд нийт нэг их наяд 126 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцсон байна.

Гэхдээ дэлхийн зах зээл дээр ашигт малтмалын үнэ хэлбэлзэлтэй хэвээр. Тухайлбал, зэсийн үнэ унах хандлагатай буйг судлаачид анхааруулсан.

Товчхондоо,
гадаадын хөрөнгө
оруулалт буурсан,
олон жил найдаж
ирсэн экспортын гол
бүтээгдэхүүний үнэ
унасан, зах зээл нь
хүндрэлтэй буй ийм
үед 2015 оны төсөв
батлагдлаа.

Нэгдсэн төсөвтэй болох ёстой ч асуудал бас байна

Төсөв бол Монгол Улсын төрийн бодлого хэрэгжүүлэх санхүүгийн үндсэн эх сурвалж. Тиймээс нэг төсөвтэй болох ёстой гэж эдийн засагч, судлаачид байр сууриа илэрхийлсээр ирсэн. Төсвөөс гадуурх мөнгөн урсгал өмнөх хоёр жилд маш их байсан. Одоо ч байгаа. “Ийм байдал манайд тохирохгүй, нэгтгэх ёстой. Үүнийг бүхэлд нь тооцож байж Монгол

Улсын төрийн бодлогыг тодорхойлж байх нь зүйтэй. УИХ-ын баталсан төсвөөс гадна Засгийн газрын мэдлийн хүрээнд мөнгөн урсгал байгаад буй нь учир дутагдалтай. Үүнийг төсвийн тодотголоор ч юм уу аль болох хурдан хугацаанд нэг төсөвтэй болох ёстой. Тэгэхээр төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас хэтрэхгүй гэсэн заалт зөрчигдөж таарна” хэмээн эдийн засагч Ж.Дэлгэрсайхан хэлсэн.

Хэдийгээр Монгол Улс нэгдсэн төсөвтэй болох ёстой гэдэгтэй эрх баригчид санал нэгдсэн ч 2015 оны төсөвт Хөгжлийн банкны зарлагыг оруулж тооцсонгүй. Энэ талаар Л.Амар “Цаашид Хөгжлийн банкны төсвийн шинжтэй зарлагыг төсвийн хязгаарт багтааж оруулж ирэх нь урт хугацаандаа төсвийн сахилга батад чухал ач холбогдолтой. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг үзэл санааных нь дагуу хэрэгжүүлэх нь төсвийн сахилга батад мөн төсвийн зарлагыг бизнесийн циклийн хамаарлаас гаргахад амин чухал үүрэгтэй. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр сэргэх үед хөрөнгө оруулалт орж ирнэ. Тиймээс энэ цаг үед бид бэлдэж, мөн баялгийн хараалаас сэргийлэхийн тулд олон улсын жишигт нийцүүлсэн Баялгийн сангийн тухай хуулийг батлах шаардлага байна. Одоо баталчихвал ирээдүйд орж ирэх хөрөнгийн урсгалаас дотоодын эдийн засгаа хамгаалах хэрэгсэл болно” хэмээсэн.

Эдийн засаг эмзэг байгаа үед төсвийн алдагдлыг өсгөх нь дарамт болдог аж. Тиймээс алдагдлыг нэмэгдүүлэх зарчмыг баримтлах боломжгүй учраас нэг төсөвтэй болж чадаагүй гэх.

Төсөвт тодотгол хийнэ

Ирэх оны эцэст инфляци долоон хувьтай байх эсэх нь эдийн засгийн нөхцөл байдал болон цаашид авч хэрэгжүүлэх бодлогоос ихээхэн хамааралтай. Мөнгөний хатуу бодлого барьж байж инфляцийг долоон хувьд хүргэнэ. Хэрэв Төвбанк уламжлалт бус хэлбэрээр зах зээлд мөнгө нийлүүлэх, эсвэл бодлогынхоо хүүд өөрчлөлт оруулах замаар бодлогоо зөөллөвөл эргээд инфляцийн дарамтад орох магадлалтай аж. Түүнчлэн валютын ▶

▶ ханшийг 1750 төгрөгөөр тооцсон. Энэ талаар Л.Амар “Валютын ханш зах зээлийн зарчмаар тогтдог. Хөвөгч бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь эдийн засгийг тэнцвэрийг хангах хамгийн чухал хэрэгсэл юм. Түүнээс бус валютын ханшийг зорилтот тоо руу аваачих нь манайх шиг жижиг, нээлттэй эдийн засагтай, валютын нөөц харьцангуй бага оронд маш их эрсдэл дагуулна. Өөрөөр хэлбэл, валютын ханш эрэлт нийлүүлэлтэд үндэслэж, чөлөөтэй хөвөгч хэлбэрээр тогтох ёстой. Энэ нь эдийн засгийн гадны сөрөг нөлөөнөөс хамгаалах маш чухал хүчин зүйл болно” гэв.

Үүнээс гадна гадаад худалдааны алдагдал валютын урсгалд ихээхэн хамааралтай. Өнгөрсөн хугацаанд энэ алдагдал буурсан гэх төлбөрийн тэнцэл гарч байсан. Хэдийгээр алдагдал буурсан ч эдийн засагт сайн дүр төрхийг авчрахгүйг судлаачид хэлсэн. Төлбөрийн тэнцэл 2012 онд 1.7 тэрбум сая ам.долларын ашигтай байсан бол өнгөрсөн онд 1.8, энэ оны эхний хагас жилийн байдлаар 500 тэрбум ам.долларын алдагдалтай гарчээ. Өөрөөр хэлбэл, сард 100 гаруй сая ам.долларын алдагдалтай яваад байна гэсэн үг. Ирээдүйд хийх хөрөнгө оруулалтыг дэмжих техник, тоног төхөөрөмж авах хэсэгт буурсан байна. Тэгэхээр эдийн засгийг төрөлжүүлэх, экспортын эх үүсвэрийг нэмэгдүүлснээр төлбөрийн тэнцлээ сайжруулж, гадаад валют орох сувгаа олшруулах хэрэгтэй байгаа аж.

2015 оны төсөв хэлэлцэж байх үед шинэ Ерөнхий сайд томилогдоогүй байв. Засгийн газрын бүтэц, Ерөнхий сайд нь томилогдоогүй байхад баталсан учраас ойрын хугацаанд төсөвт тодотгол хийхээс өөр аргагүй гэдгийг шинээр томилогдсон гүйцэтгэх засаглалын тэргүүн хэлсэн. Засгийн газар шинэ бүтцээр ажиллах учир төсөвт зайлшгүй тодотгол хийх шаардлага байгаа юм. Тэр үед зарлага болон орлогын төлөвлөлт, төсвөөс гадуурх мөнгөн урсгалаа хэрхэн оруулж ирэх талаар дахин ярилцана.

Бүсээ чангалж, хэмнэлт хийх гэж оролдсон төсөв болсон гэж буй ч тодотголоор зарим зүйлийг дахин танах аж. Товчхондоо, гадаадын хөрөнгө оруулалт буурсан, олон жил найдаж ирсэн экспортын гол

бүтээгдэхүүний үнэ унасан, зах зээл нь хүндрэлтэй буй ийм үед 2015 оны төсөв батлагдлаа. Дээрээс нь энэ оны төсвийн орлого 980 тэрбум төгрөгөөр

тасраад буй. Энэ их мөнгө он дуусахад гэнэт орж ирэхгүй. Тиймээс зарлага болоод хөрөнгө оруулалтыг дахин танах шаардлага бий юм. ■

ТӨСӨВ -2015

ЗАРЦУУЛАЛТЫН ЗАДАРГАА

Э.ЗОРИГ

Ирэх оны улсын төсөв батлагдаад удаагүй байгаа энэ үед “Mongolian economy” сэтгүүл төсвийн зарцуулалтын задаргааг уншигч танд хүргэж байна.

Ирэх оны төсөв хоёр онцлогтой аж. Эхнийх нь улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй бүтээн байгуулалтын ажил он, жил дараалан сунжирдаг байдлыг халах. Үүний тулд хөрөнгө мөнгийг төслүүдэд амсуулаад өнгөрдөг байдлыг халжээ. Харин хэрэгтэй санхүүжилтийг нь бүрэн өгөхөөр болсон байна. Тиймээс ирэх оны төсөвт тусгагдсан нийт төслийн 80 гаруй хувь нь тухайн ондоо багтаад дуусах аж. /Төслүүдийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүйг хүснэгтээс харна уу/

Хоёр дахь онцлог нь энэ оны төсөвт царцаасан төслүүдийг бүгдийг 2015 оны төсөвт суулгаж өгсөн байна. Тийм болохоор ирэх жил урд өмнө нь хийгдэж байгаагүй бүтээн байгуулалтын ажил өрнөх нь. Тухайлбал, ирэх онд 34 цэцэрлэг, 10 цахилгаан дамжуулах агаарын шугам, 53 сургууль, 18 дотуур байр, 14 спорт заал, усан бассейн, 37 Соёлын төв, 27 эмнэлэгийн барилга тус тус улсын хэмжээнд ашиглалтад орох ажээ.


Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо

Нийт төслийн тоо	2015 онд дуусах	2016 онд дуусах	2017, 2018 онд дуусах
457 төсөл	393 төсөл	60 төсөл	2017-3/ 2018-1
100%	85.9%	13.1%	0.8%

Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо

Нийт төслийн тоо	2015 онд дуусах	2016 онд дуусах	2017 онд дуусах
22 төсөл	19 төсөл	2 төсөл	1 төсөл
100%	86.4%	9.1%	4.5%

2015 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт 655.4 тэрбум төгрөг байна



Эх сурвалж: Сангийн яам

Улсын төсвийн мөнгийг хэн, хаана, хэрхэн зарцуулахыг доорх хүснэгтээс харна уу.

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн / сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	7,676.2
	Урсгал зардал	7,676.2
2	Монгол Улсын Их Хурлын дарга	27,327.9
	Урсгал зардал	25,175.3
3	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	2,152.6
	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	722.4
4	Урсгал зардал	722.4
	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	3,902.7
5	Урсгал зардал	3,902.7
	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	54,854.8
6	Урсгал зардал	54,854.8
	Хүний эрхийн үндэсний комиссын дарга	849.5
7	Урсгал зардал	849.5
	Улсын ерөнхий прокурор	20,386.6
8	Урсгал зардал	17,445.0
	Хөрөнгийн зардал	2,941.6
9	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	2,124.5
	Урсгал зардал	2,124.5
10	Монгол Улсын Ерөнхий аудитор	8,556.3
	Урсгал зардал	8,556.3
11	Авлигатай тэмцэх газрын дарга	9,927.7
	Урсгал зардал	9,927.7
12	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	3,654.2
	Урсгал зардал	2,550.8
13	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	1,103.4
	Төрийн албаны зөвлөлийн дарга	630.7
14	Урсгал зардал	630.7
	Үндэсний статистикийн хорооны дарга	8,665.8
15	Урсгал зардал	8,665.8
	Сонгуулийн ерөнхий хорооны дарга	950.2
16	Урсгал зардал	950.2
	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга	683.4
17	Урсгал зардал	683.4
	Монгол Улсын Ерөнхий Сайд	86,526.4
18	Урсгал зардал	72,573.3
	Хөрөнгийн зардал	7,083.6
19	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	6,869.5
	Монгол Улсын Шадар сайд	113,777.4
20	Урсгал зардал	88,002.3
	Хөрөнгийн зардал	21,235.1
21	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	4,540.0
	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	22,847.0
22	Урсгал зардал	14,939.7
	Хөрөнгийн зардал	4,368.7
23	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	3,538.6
	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд	80,463.7
24	Урсгал зардал	58,661.6
	Хөрөнгийн зардал	8,389.5
25	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	13,412.6
	Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны сайд	56,552.9
26	Урсгал зардал	52,317.9
	Хөрөнгийн зардал	4,200.0
27	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	35.0
	Сангийн сайд	2,296,634.1
28	Урсгал зардал	1,100,832.8

Дотоод эх үүсвэрээс олгох зээл	63,471.8	
Хөрөнгийн зардал	62,435.3	
Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	24,516.3	
Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөрт	898,654.1	
Засгийн газрын гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт	141,400.6	
Засгийн газрын дотоод зээлийн үндсэн төлбөрт	5,323.3	
22	Хууль зүйн сайд	425,307.0
Урсгал зардал	367,825.3	
Хөрөнгийн зардал	57,481.7	
23	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд	324,444.4
Урсгал зардал	25,555.8	
Үүнээс: Газрын харилцаа, кадастрын тусгай зориулалтын шилжүүлэг	7,014.7	
Хөрөнгийн зардал	145,896.6	
Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	152,997.1	
24	Батлан хамгаалахын сайд	201,345.1
Урсгал зардал	184,985.8	
Хөрөнгийн зардал	8,818.1	
Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	7,541.2	
25	Боловсрол, шинжлэх ухааны сайд	1,140,965.9
Урсгал зардал	941,128.5	
Үүнээс:		
Сургуулийн өмнөх боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг	246,795.3	
Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг	526,932.0	
Дотоод эх үүсвэрээс олгох зээл	21,837.2	
Хөрөнгийн зардал	168,454.2	
Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	9,546.0	
26	Соёл, спорт, аялал жуулчлалын сайд	214,791.8
Урсгал зардал	98,997.0	
Үүнээс:		
Соёлын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	42,335.6	
Нийтийн биеийн тамирын тусгай зориулалтын шилжүүлэг	138.1	
Соёл, нийтийн биеийн тамирын тусгай зориулалтын шилжүүлэг	10,515.9	
Хөрөнгийн зардал	115,794.8	
27	Уул уурхай, эрчим хүчний сайд	98,341.7
Урсгал зардал	39,442.1	
Хөрөнгийн зардал	42,997.3	
Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	15,902.4	
28	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд	167,608.0
Урсгал зардал	117,260.5	
Дотоод эх үүсвэрээс олгох зээл	2,100.0	
Хөрөнгийн зардал	21,978.6	
Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	26,268.8	
29	Хөдөлмөрийн сайд	410,859.7
Урсгал зардал	371,367.5	
Дотоод эх үүсвэрээс олгох зээл	24,000.0	
Хөрөнгийн зардал	14,912.3	
Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	580.0	
30	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	409,050.3
Урсгал зардал	392,243.8	
Үүнээс: Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	6,554.1	
Хөрөнгийн зардал	14,386.9	
Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	2,419.6	
31	Эрүүл мэндийн сайд	606,131.4
Урсгал зардал	484,866.9	
Үүнээс: Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	99,440.1	
Хөрөнгийн зардал	57,625.4	
Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	63,019.2	

Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтаас хөгжлийн банкинд шилжүүлэх төсөл, арга хэмжээ

	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг /сая төг/	2015 онд санхүүжих дүн /сая төг/	Төсвийн ерөнхийлөн захирагч
		Эхлэх	Дуусах			
1	Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах /Улаанбаатар/	2014	2015	9 000,0	6 500,0	Уул уурхай, эрчим хүчний сайд
2	Залаат, Бага тэнгэр, Их тэнгэрийн ам, Хан-Уул, Баянзүрх дүүргийн хорооллуудын цахилгаан хангамжийг сайжруулах зорилгоор 110/10 кВ-ын дэд станц, 110 кВ-ын 7.6 км цахилгаан дамжуулах агаарын шугам / Улаанбаатар/	2014	2015	8 969,3	4 469,3	Уул уурхай, эрчим хүчний сайд
3	Баруун-Урт-Асгат-Эрдэнэцагааны 35 кВ-ын 197 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, 110/35/6 кВ-ын дэд станцын өргөтгөл /Сүхбаатар/	2014	2015	8 400,0	5 400,0	Уул уурхай, эрчим хүчний сайд
4	Хорооллын гадны цахилгаан хангамж 6/0.4 кВ-ын 2х630 кВа ХТП-15 ком, 6кВ-ын 34,9 км кабель шугам / Дархан-Уул, Дархан сум, 11, 12, 24, 25, 26 дугаар хороолол/	2014	2015	9 715,0	6 215,0	Уул уурхай, эрчим хүчний сайд
5	Хорооллын гадны цахилгаан хангамж 6/0.4 кВ-ын 2х630 кВа ХТП-8 ком, 6 кВ-ын 10,5 км кабель шугам / Дархан-Уул, Дархан сум, 2, 3 дугаар хороолол/	2014	2015	4 969,0	3 469,0	Уул уурхай, эрчим хүчний сайд
6	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын өргөтгөл, шинэчлэлт /улсын хэмжээнд/	2014	2015	17 000,0	12 000,0	Уул уурхай, эрчим хүчний сайд
7	Мардай-Чулуунхороот сумын 35 кВ-ын 160 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорнод/	2012	2015	4 397,4	3 358,5	Уул уурхай, эрчим хүчний сайд
8	Цагаансуварга-Мандахын 22 кВ-ын 60.85 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорноговь, Мандах сум/	2015	2015	2 863,0	2 863,0	Уул уурхай, эрчим хүчний сайд
9	Цагаансуварга-Хатанбулагийн 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих /Дорноговь, Хатанбулаг сум/	2015	2015	7 265,0	7 265,0	Уул уурхай, эрчим хүчний сайд
10	Төгрөг-Бугатын 15 кВ-ын 52,5 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Говь-Алтай, Бугат сум/	2015	2015	1 800,0	1 800,0	Уул уурхай, эрчим хүчний сайд
11	Дарханы дулааны цахилгаан станцад хягдал үнсэн сан шинээр барих /Дархан-Уул/	2014	2015	8 147,5	5 147,5	Уул уурхай, эрчим хүчний сайд
12	Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээллийг бий болгох /улсын хэмжээнд/	2012	2016	15 000,0	4 455,0	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
13	Инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/	2014	2015	4 374,3	2 124,3	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
14	Цэвэр, бохир усны шугам сүлжээ, усан сан, насосны станц, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт / Улаанбаатар, Багахангай дүүрэг/	2013	2015	7 600,0	5 600,3	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
15	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид 2 дугаар тунгаагуур 2 ширхэг, биоцөөрөм барих / Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2013	2015	8 519,1	4 135,3	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
16	Аймгийн төвийн 1000 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам, сүлжээ /Баянхонгор, Дорноговь, Төв, Говьсүмбэр, Булган, Увс, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон, Сүхбаатар, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий/	2013	2017	62 000,0	9 604,8	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
17	Сумын төвийн шинэчлэл төсөл /Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Өвөрхангай, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Өмнөговь, Төв, Увс, Ховд, Хэнтий, Хөвсгөл аймагт тус бүр нэг сум/	2014	2016	80 000,0	19 877,7	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
18	Элсэн тасархай-Хархорины Орхоны гүүр чиглэлийн 77 км хатуу хучилттай замын шинэчлэл /Өвөрхангай/	2012	2015	26 965,1	17 020,2	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
19	Ханх-Мондын чиглэлийн 23 км хатуу хучилттай авто зам /Хөвсгөл, Ханх сум/	2012	2015	14 340,4	9 352,0	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
20	Мөрөн сумын дунд тойргийн 9.8 км хатуу хучилттай авто замын өргөтгөл /Хөвсгөл, Мөрөн сум/	2012	2015	8 300,0	3 000,0	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
21	Сэлэнгэ мөрний төмөр бетон 422.5 у/м гүүр /Булган, Сэлэнгэ сум/	2013	2016	11 042,0	6 000,0	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
22	Дэлгэрмөрөн голын хөвдөг гүүр, бирваазын шинэчлэл /Хөвсгөл, Баянзүрх сум/	2015	2015	1 500,0	1 500,0	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
23	Сэлэнгэ мөрний дөрөө хангинахын хөвдөг гүүр /Хөвсгөл, Их-Уул сум/	2015	2015	1 500,0	1 500,0	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
24	Ерөө голын төмөр бетон гүүр /Сэлэнгэ/	2015	2015	5 200,0	5 200,0	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
25	Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан монголын талын гүйцэтгэх төсөл арга хэмжээ /Төв, Сэргэлэн сум, Хөшигийн хөндий/	2012	2016	122 874,2	38 000,0	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
26	Аймгийн төвөөс хилийн боомтууд чиглэлийн хатуу хучилттай автозамуудын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах /Дорнод, Хэрлэн сум, Баянхошуу боомт, Хавиргын боомт, Ульхан боомт/	2015	2015	1 700,0	1 700,0	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
27	Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах /Дархан-Уул, Дархан сум/	2014	2015	16 000,0	8 000,0	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд
НИЙТ				469 441,2	195 556,8	

Эх сурвалж: Сангийн яам

ТӨСӨВ-2014

ОРЛОГОГҮЙ ТӨСӨВ ХӨГЖЛИЙН ЗАРЛАГАГҮЙ

Б.ТОГТОХ

Огцорсон Засгийн газрын үйлдвэрлэсэн хоёр дахь төсөв энэ оноор хаалтаа хийнэ. Монгол Улсын нийт мөнгөний 40 орчим хувийг эзлэх төсөвт шийдэж чадаагүй асуудал олон бий. Хариуцлага тооцох эзэнгүй төсвийн орлого өнгөрсөн сарын байдлаар 778 тэрбум төгрөгөөр тасарсныг Сангийн яамнаас мэдэгдлээ. Төсвийн итгэл алдарсан өдрүүд үргэлжилсээр. Бага орлоготой орноос дундаж орлоготой орны тоонд багтсан Монгол оронд орлого тасрах нь хөгжил зогссонтой бараг л

ижил. Тиймээс энэ онд хийгдэх ёстой байсан нийгмийн чанартай бүтээн байгуулалтууд царцаж байна.

Эдийн засгийн хүндрэлээс үүдэн хөгжлийн хөрөнгө оруулалтууд ирэх онд шилжихгүй нь. Ингэснээр сургууль, цэцэрлэг, эмнэлэг тулгамдсан асуудал хэвээр үлдээнэ гэсэн үг. Тухайлбал, Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт эрүүл мэндийн үйлчилгээ авахад нэн бэрх байгааг иргэд учирлах аж. Эмчлүүлэн хэвтэх өргүйгээс коридорт зулан хэвтэх нь ердийн үзэгдэл болж. Хэт ачааллаа дийлэхгүй байгаагаас дүүргийн эрүүл мэндийн төвд ажиллаж

буй эмч нар бухимдалтай, тэнд эмчүүлж буй хүмүүс сэтгэл дундуур үйлчилгээ авсаар. Орлогогүйн улмаас шинэ төрөх болон хүүхдийн эмнэлэг барих асуудал нэг талаар хойшилж байгаа юм. Гэхдээ хамгийн чухал асуудал хамгийн сүүлд эрэмблэгдэж байна.

2014 оны төсвийн орлого 6.8 их наяд төгрөг. Оны эцэс гэхэд орлогын тасалдал нийтдээ 850 тэрбум төгрөгт хүрч, орлого 10.1 хувиар тасрах төлөвтэй байна. Тус яамны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтсийн дарга М.Батгэрэл "Олон ▶



► улсын зах зээлд ашигт малтмалын үнэ унасан тул түүнийг дагаад Монгол Улсын төсвийн орлого тасардаг” гэв. Төсвийн орлогын тасалдалд макро эдийн засгийн өнөөгийн байдал, экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ, түүний тоо хэмжээний бууралт голлох нөлөө үзүүлсэн байна.

УИХ-ын гишүүн Р.Амаржаргал “Оны төгсгөлд төсвийн орлого нэг их наяд төгрөгийн алдагдалтай гарахад нэг их гайхах хэрэггүй” хэмээсэн. Тэрбээр 2013 оны төсвийн орлого 1.5 их наядаар тасарч байсныг мөн нэмж дурьдсан юм.

Төсөвт энэ оны эдийн засгийг бодитоор 14.8 хувиар тэлж, нэрлэсэн дүнгээр ДНБ-ий хэмжээ 20.4 их наяд төгрөгт хүрэхээр зурагласан. Монгол Улсын эдийн засгийн чадамж бараг л хоёр дахин нугарч, өсөлт 2013 оныхоос дөрвөн хувиар хурдаа нэмэх байлаа. Үнэхээр өөдрөг төсөөлөл. Харамсалтай оны эхний хагаст эдийн засаг 5.3 хувиар тэлж, монголчуудын урмыг хугаллаа. Үлдсэн хугацаанд эдийн засгийн жилийн өсөлт долоо орчим хувьд хүрэх төлөвтэй байгааг төсөв зохиосон Сангийн яамнаас танилцуулж, бодит байдлаа нуусангүй. Харин Монголбанкны зүгээс 3.6 хувиар эдийн засаг өснө гэсэн таагүй мэдээг өнгөрсөн сард задалж орхисон.

2014 оны төсвийн хөрөнгө оруулалтын зардал 1.1 их наяд төгрөг. Үүний 930.3 тэрбум төгрөгөөр барилга байгууламж барих байлаа. Энэ нь нийт хөрөнгө оруулалтын 81.4 хувийг эзэлж буй. Үүгээр 69 цэцэрлэг, 49 сургууль, 28 дотуур байр, 30 эмнэлэг, 27 соёлын төв, 681 км хатуу хучилттай зам барих байсан. Мөн таван цэвэрлэх байгууламж, 1032 метр төмөр бетон гүүр байгуулахаар тогтсон. Гэвч орлого бүрдээгүйн улмаас дээрх бүтээн байгуулалтын дийлэнх нь цаасан дээр үлдэж байна. Урсгал зардлаа даахгүй, бүтээн байгуулалтгүй төсөв цалин, тэтгвэр, тэтгэмжээ бондын мөнгөөр орлуулж байгаа нь ил болсон.

Төсвийн орлого зөвхөн нэг салбараас хэт хараат байх нь эдийн засаг дахь эмзэг байдлыг улам дэвэргэх аж. Энэ нь эдийн засгаа төрөлжүүлэх, орлогын сувгаа өргөсөх шаардлага байгааг илтгэнэ. Өмнөх жилүүдэд төсвийн орлогыг бүрдүүлж байсан нүүрс, төмрийн хүдэр, жонш зэрэг голлох нэр төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оныхоос 22 хувиар буурсан байна. БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан манай улсаас экспортолсон нүүрсний үнэ төлөвлөсөн хэмжээнээс 40 хувиар унажээ. Мөн төмрийн хүдрийн экспортын хэмжээ 36 хувиар буурсан нь уул уурхайн салбараас төвлөрөх орлого энэ онд дахиад л дутах нь нэгэнт тодорхой боллоо.

Манай улс энэ онд 31.4 сая тонн нүүрс экспортолно хэмээн төсөвт тооцсон. Одоогийн байдлаар төлөвлөсөн хэмжээнийхээ дөнгөж гуравны нэгээс арай илүүг экспортолжээ. Нэгдсэн

төсвийн нийт орлогын 12 хувийг уул уурхайн салбар олох учиртай. Энэ нь 1.4 их наяд төгрөг. Гэвч дээрх байдлаас шалтгаалан төсөвт эзлэх уул уурхайн салбарын байр суурь үл ялиг ганхаад эхэллээ. “Хэт өөдрөг төсөв” хэмээн энэ оны улсын нэгдсэн төсвийг Дэлхийн банкнаас дүгнэж байсан. Харин Сангийн яамнаас “Сургамжтай төсөв болсон” хэмээн онцолж байлаа, жилийн өмнө.

УИХ-ын гишүүн Р.Амаржаргал “Оны төгсгөлд төсвийн орлого нэг их наяд төгрөгийн алдагдалтай гарахад нэг их гайхах хэрэггүй” хэмээсэн. Тэрбээр 2013 оны төсвийн орлого 1.5 их наядаар тасарч байсныг мөн нэмж дурьдсан юм. Орлогогүй төсөв хөгжлийн зарлагагүй. Энэ тохиолдолд ирэх намар сургууль, цэцэрлэг “од” болж, түүний төлөөх өрсөлдөөн улам ширүүснэ. Эрүүл мэнд болон боловсролын үйлчилгээ авч чадахгүй байгаа иргэдийн тоо нэмэгдэж, хүмүүн капитал нийгмийн гадна үлдэх эрсдэлтэй. ■

МӨНГӨНИЙ БОДЛОГО

ИНФЛЯЦИ БАС ДАХИН ИНФЛЯЦИ

Б.БАЯРТГОТХ

Уламжлалт бус мөнгөний бодлогын хүрээнд амжилттай хэрэгжиж буй хөтөлбөрийн нэг нь орон сууцны урт хугацаат зээл. Өнгөрсөн аравдугаар сарын байдлаар нийт зээлдэгчдийн тоо 63 мянга давсан. Монголбанкны итгэл үнэмшил болсон ипотекийн зээл өрхийн нийт зардал дахь эрэлтийг хязгаарлаж, хэрэглээг жолоодсон хэмээн Төвбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал онцолсон удаатай. Ипотекийн зээл нь хуримтлалын нэг хэлбэр юм. Найман хувийн зээлийн

төлбөрт хамгийн багадаа 120 мянган иргэн сар бүр өрхийн орлогынхоо 30-45 хувийг хуримтлал болгож, зээлийн төлбөрт дунджаар 30 тэрбум төгрөгийг төвлөрүүлж байна. Энэ нь харагдах талдаа орон сууцны зээл боловч өөртөө хийж буй томоохон хөрөнгө оруулалт.

Ирэх онд тогтворжуулах хөтөлбөрүүдийн зарим нэгийг нь зах зээлийн хуулиар явуулна. Тухайлбал, энэ сард багтаан ОХУ-ын Төвбангтай Монголбанк своп хэлцэл байгуулахаар болсныг Ерөнхий сайд Ч.Сайханбилэг ►

► мэдэгдсэн. Ам.долларын ханшид сар тутам дарамт учруулдаг байсан шатахууны импортыг дээрх байдлаар шийдэх аж. Өөрөөр хэлбэл, ОХУ-тай хийх гадаад худалдаагаа рублиэр хийдэг тогтолцоонд шилжүүлэх юм байна. Ингэснээр манай ам.долларын хамгийн том зардал рубльд шилжиж, ханшид шууд эерэг нөлөөлөл бий болгох юм. Харин ипотекийн зээл Төвбанкны дэмжлэгтэйгээр ирэх онд үргэлжилнэ.



“Эрэлт, нийлүүлэлтийн зохистой бодлогын үр дүнд инфляцийн түвшин 2015 онд хүсээд буй үр дүнд ойртох болно” гэж Н.Золжаргал ерөнхийлөгч мэдэгдсэн. Энэ оны төгсгөлд инфляцийн өсөлт 1.1 хувиар буурах таамгийг Монголбанкны судалгааны хэлтсээс мөн гаргаад байгаа. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд авч хэрэгжүүлсэн бодлогын нөлөөгөөр нийт инфляцийн 40 орчим хувийг нийлүүлэлтийн гаралтай инфляци эзэлдэг байжээ. Тэгвэл одоо нийт инфляцийн өсөлтийн таван хувийг нийлүүлэлтийн гаралтай инфляци бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрүүдийн үр дүнд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн “шок” эрс багасчээ.

Ирэх онд хэрэгжих мөнгөний бодлогын үндсэн агуулгыг “нам, тогтвортой инфляци, санхүүгийн тогтвортой

байдал ба макро эдийн засгийн тэнцвэр” хэмээн Монголбанкны Ерөнхийлөгч томъёолсон. Амаргүй сорилт Монголбанкийг төдийгүй шинэ Засгийн газрыг угтаж байна. Эдийн засаг халуурсан, асуудал хүндэрсэн эгзэгтэй цаг үед тэдний бодлого хэрэгжинэ. Төлбөрийн тэнцлийн нийт алдагдал ДНБ-ий 24 хувьд хүрч, ам.долларын ханш 1900 төгрөгтэй тэнцсэн. Гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом унаж, 5.8 их наяд

төгрөгөөр буураад байна. Эдийн засагт үлэмж нөлөөтэй томоохон төслүүдийн хэрэгжилт он дамнан удааширч тодорхой бус байдал хэвээр сунжирлаа. Гадаад худалдааны нөхцөл муудсан, шинэ хөрөнгө оруулалтын итгэл алдарсан гунигтай өдрүүд үргэлжилсээр. Түүний эцсийн зогсоол 2014 он лавтай биш бололтой. Ийм нөхцөлд хямралыг сөрсөн мөнгөний бодлого хэрхэн үр дүн хүрэх эсэхийг хүлээх үлдлээ.

Ирэх жилийн Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг УИХ-ын гишүүд өнгөрсөн сард 40 гаруй хоног хэлэлцэж баталсан. Ингэснээр Монголбанкны санхүүгийн жил албан ёсоор эхэллээ. Дотоодын хуримтлалыг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих үүрэг хүлээсэн шинэ мөнгөний бодлого өндөр инфляцийн эсрэг “мордлоо”. Иргэдийн бодит орлогыг хамгаалах, түүнд ирэх ачааллыг зөөлрүүлэх үүднээс жил

бүр Төвбанк инфляцийг онилж ирсэн. Тэгвэл 2015 онд мөн адил одоогийн инфляцийн түвшинг бууруулах, нэг оронтой тоонд царцаах зорилтоо тэд ахин дэвшүүллээ.

Улсын хэмжээнд энэ оны аравдугаар сарын байдлаар инфляци 12.1 хувьд хүрээд буй. Түүний өсөлтийг сааруулах замаар долоон хувиас хэтрүүлэхгүйгээр тогтоох хүслээ Монголбанкны удирдлага бодлого болгосон. Энэ нь дунд болон урт хугацаанд эдийн засаг тогтвортой хөгжих, дундаж давхарга нэмэгдэх, төгрөгийн өрсөлдөх чадварт эерэг нөлөө үзүүлэх чухал сонголтын нэг аж. Монголбанк, Засгийн газар хооронд макро эдийн засгийн нэгдсэн мэдээллийн тогтолцоог ирэх онд бий

Дотоодын хуримтлалыг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих үүрэг хүлээсэн шинэ мөнгөний бодлого өндөр инфляцийн эсрэг “мордлоо”.

болгохоор үндсэн чиглэлд зурагласан. Ингэснээр төсөв, мөнгөний бодлогын уялдаа холбоо сайжрах давуу талтай аж.

Нийгмийн даатгал, Тэтгэврийн сангийн тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх. Түүнчлэн Баялгийн сангийн эрх зүйн орчныг бүрдүүлэх үүргийг УИХ мөнгөний бодлогын хүрээнд Монголбанкинд олгожээ. Өөрөөр хэлбэл, Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлээр дамжуулан дээрх асуудлыг баталгаажуулсан байна. Энэ нь Монголбанк үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангахын тулд Санхүүгийн зохицуулах хороотой нягт хамтран ажиллах нь оновчтойг гэдгийг өгүүлсэн хэрэг. Монголбанкны толгойн өвчин болсон инфляци давхар оронтой тоонд олон жил яваа. Импорттоос бүрэн хамааралтай эдийн засагтай орны хувьд түүнийг дан болгох нь үргэлж мөрөөдөл хэвээр байсан. ■



Задгай мөнгөний үнээгүйдэл инфляци үүсгэдэг

МӨНГӨ

ИНФЛЯЦИЙН ЧӨДӨР

Э.ЗОРИГТ

Гэрийн сангийн сайд гэргий маань сүүлийн үед нэг л бухимдуу. Улс орны эдийн засгийн хямрал өрхийн төсөвт дарамт үүсгээд, орлого нь тасалдаад, мах гурил үнэд ороод байхаар ийн цухалдах нь аргагүй биз ээ. Инфляцийг онилдог Төвбанк энэ жил үнийн өсөлтийг нэг оронтой тоонд барина гэсэн амлалтаа биелүүлсэн бол “сангийн сайд” маань уургүй өнжихсөн.

Монголбанк инфляцийг 2014 оны

эцэс гэхэд найман хувь, 2015-2016 онд долоон хувиас хэтрэхгүй түвшинд байлгах зорилт тавьжээ. Ингэснээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу инфляцийг хязгаарлах, мөнгө, төсвийн бодлогын харилцан уялдааг хангах чиглэлээр Засгийн газартай хамтран ажиллана гэсэн. Уг нь тэд гар нийлж ажилласан тохиолдолд макро эдийн засгийн тогтвортой байдал бэхжих учиртай байлаа. Гэтэл байдал эсэргээрээ эргэж эдийн засаг унаж, үнийн өсөлт 12.1 хувьтай байна.

Үнийн өсөлтийн шалтгаан

Өнөөгийн инфляцийн өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийн дийлэнх хувийг төгрөгийн ханшийн сулрал эзэлж байгааг Үндэсний статистикийн хорооноос гаргасан инфляцийн задаргаанаас харж болно. Ийн суларсан нь үндсэн хоёр шалтгаантай аж. Эхнийх нь манай экспортын барааны дэлхийн зах зээлийн үнэ унасан. Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом багассан. Ийм ▶

► нөхцөлд дотоодын ам.долларын нийлүүлэлт багасаж, эрэлт нь өсөх үйл явц бий болж, улмаар ам.долларын үнэ өсч төгрөгийн ханш унасныг бүгд мэдэж буй. Үүнээс гадна инфляци өсөхөд нөлөөлсөн урт болон дунд хугацааны олон хүчин зүйл байгаа аж. Энэ талаар МУИС-ийн Бизнесийн сургуулийн багш, доктор, санхүүгийн зөвлөх профессор Л.Оюун “Инфляци бол ханшийн өсөлт. Тэгвэл ханшийн өсөлтийг тухайн орны мөнгөн дэвсгэртээр илэрхийлнэ. Гэтэл манай улсын мөнгөн дэвсгэртийн задгай мөнгө нь үнэгүйдчихсэн байна. Үүнийг батлах хэд хэдэн жишээ татаж болно. Тухайлбал, бид 2005 оноос “Задгай мөнгөний эрэлт ба нийлүүлэлт” судалгааг хийж эхэлсэн юм.

хувьд 1-50 хүртэлх төгрөгийг бараг үнэлдэггүй нь “Задгай мөнгөний эрэлт ба нийлүүлэлт” судалгаагаар харуулжээ. Хэрвээ монголчууд задгай мөнгөө үнэлж сурахгүй бол задгай мөнгөөр худалдаж авдаг бараа бүтээгдэхүүн байхгүй болно гэсэн үг. Товчхондоо, бүх бараа бүтээгдэхүүний үнэ бүхэл мөнгөн дүнгээр илэрхийлэгдэж, үнэ нь улам өсөх аж.

Задгай мөнгөний ид шид

Мөнгөний бодлогын тэргүүн зорилт нь инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгаж, макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн

хэмжээг амжилттай хэрэгжүүлжээ.

Инфляцийг хазаарлах гээд өнөөдрийг хүртэл үл чадсан Орос, Казахстан, Беларус зэрэг орон мөнгөний реформ хийсэн нь өгөөжөө хүртээгээд эхэлсэн. Хойд хөршийн хувьд хуучин 1000 рублийг шинэ нэг рубльтэй тэнцүү болгож ханшийн өөрчлөлт хийжээ. Ингэснээр задгай мөнгөний чадавх сайжирч хямд үнэтэй бараа бүтээгдэхүүн олширсон байна.

Цалингаа өсгө, үр дүн нь илүү сонирхолтой

Үнэ өсөөд л байдаг. Гэтэл цалин нэмэгдэх нь бүү хэл эдийн засгийн хямралын сургаар, харин ч багассан. Олон улсын туршлагаас үзэхэд цалингийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулсан байдаг. Учир нь орлогыг нэмэгдүүлж байж борлуулалт өсдөг. Орлого бага байвал борлуулалт хийгдэхгүй. Борлуулалтад саад учраад ирэхээр иргэд үйлдвэрлэл, үйлчилгээний газраар зочиллох мөнгөгүй болдог. Ийм үед үйлдвэрлэл хумигдах эрсдэлтэй. Энэ нь дам болон шууд нөлөөллөөр эдийн засгийг бүхэлд нь хямраачихдаг. Тэгэхээр үнийн өсөлтийн үед цалин индексжүүлэх арга олон улсад хэрэгжих нь бий. Гэхдээ үнийн өсөлтөөс орлогын өсөлт нь бага байхаар индексжүүлэх ёстой гэдгийг Санхүү эдийн засгийн дээд сургуулийн Санхүүгийн удирдлагын тэнхмийн багш, эдийн засагч Ж.Дэлгэрсайхан сануулсан. Учир нь үнийн өсөлтөөс орлогын өсөлт их бол инфляцийг улам “давраадаг” аж.

Ирэх оны төсөвт цалин, тэтгэврийг нэмэгдүүлэхээр 500 гаруй тэрбум төгрөг тусгасан. Энэ хэмжээний хөрөнгөөр цалин, тэтгэврийг 2.5 дахин нэмэгдүүлэх боломжтой гэж Сангийн яам мэдэгдсэн. Гэвч төсвийн алдагдал их, цаашдаа ч нэмэгдэхээр байгаа тул цалин нэмэх асуудлыг бодох хэрэгтэй гэх. Л.Оюун “Төсвийн алдагдал эдийн засагт ямар нөлөө үзүүлдэг вэ. Хариулт нь их сонирхолтой. Тэр нь төсвийн алдагдал эдийн засгийн өсөлтийг хангадаг. Тиймээс төсвийн алдагдал гарахаас айх хэрэггүй. Төсвийн алдагдал байж болно. Цалингаа нэмчихээр төсвийн ►►

Олон улсад 10 мянга, таван мянгатын мөнгөн дэвсгэрт байдаггүй. Гэтэл манайх 20 мянган төгрөгийн мөнгөн дэвсгэрт ашигладаг. Өнөөгийн нөхцөлд 20 мянган төгрөгийн дэвсгэртээ татах нь зөв байж мэдэх юм.

Судалгааны хүрээнд олон төрлийн, өөр хоорондоо хамаарал бүхий судалгааг мөн хийсэн. Тэдгээрийн нэг нь “Задгай мөнгөгүй орон байна уу” гэх судалгаа. Манай улсад задгай мөнгөний эрэлт байна уу гэдгийг судлахад, “Байгаа” гэж гарсан” гэв. Мөн судалгааны явцад олон орны мөнгөн дэвсгэртийг ажиглахад дээд талын мөнгөн дэвсгэрт нь дунджаар 100. Хамгийн ихдээ хоёр мянгын дэвсгэрттэй байх жишээтэй. Гэтэл манайх 20 мянган төгрөгийн мөнгөн дэвсгэрт ашигладаг. Уг нь олон улсад 10 мянга, таван мянгатын мөнгөн дэвсгэрт байдаггүй. Энэ нь ямар сөрөг үр дагавар авчирч байна вэ гэхээр манай задгай мөнгөний үнэ цэнийг бууруулж байгааг профессор Л.Оюун анхааруулсан юм.

Олон улсад нэг цент, нэг вонн, нэг мао гээд хамгийн бага мөнгөн дэвсгэрт хүртэл үнэ цэнэтэй мөнгөн тэмдэгт болдог. Иймд заавал хариулт болгож авдаг бас өгдөг. Харин монголчуудын

засгийн дархлааг сайжруулахад чиглэдэг. Гэхдээ мөнгөний бодлого хэм хэмжээтэй, эрх мэдэл нь хязгаарлагдмал бөгөөд үр дүн нь богино хугацаанд мэдрэгдэхгүй. Тэгвэл богино хугацаанд инфляцийг нам дарах арга нь Монголд мөнгөний реформ хийх. Тэгвэл мөнгөний реформ гэдэг нь “Мөнгөн тэмдэгтийг шинээр зах зээлд нийлүүлэх мөн буцааж татах” гэж ерөнхийд нь ойлгож болох аж. “Задгай мөнгөний эрэлт ба нийлүүлэлт” судалгааны багийнхан “Манай өнөөгийн нөхцөлд 20 мянган төгрөгийн дэвсгэртээ татах нь зөв байж мэдэх юм. Мөнгөн тэмдэгтийг татахад олон арга бий. Тухайлбал, барааны үнийн дүнгийн арын тэгийг хасч болно. Гурав, дөрвөн тэгийг нь ч хасч болно. Энэ нь нэг талаар инфляцитай тэмцэх арга. Энэ мэтээр мөнгөний үнэ цэнийг нэмэгдүүлэх арга хэмжээ авбал биднээс хамааралгүйгээр “дураараа” өсдөг инфляцийг хазаарлах боломжтой” гэсэн юм. ОХУ хэдэн жилийн өмнө ийм төрлийн арга

▶ алдагдал улам нэмэгдэнэ. Гэхдээ цалин нэмэгдэх хэрээр бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэх учиртай. Ингээд ирэхээр төсвийн орлого татвараар дамжаад мөн л нэмэгдэнэ шүү дээ. Тиймээс л цалинг индексжүүлж нэмдэг” гэв.

Эцсийн эцэст

Хэт өсөөд ирэхээрээ эдийн засгийн дархлааг сулруулчихдаг инфляци гэцийг барих олон арга олон улсад

бий. Тухайлбал, манай улсын эдийн засгийн томоохон тэтгэгч гэж болох Хятад улсын инфляцитай тэмцдэг гол арга нь бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэх аж. Урд хөрш бол үйлдвэрлэгч орон. Тиймээс тэнд ямар нэг бараа, бүтээгдэхүүний үнэ өсөхөд тус төрлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг төрийн бодлогоор нэмдэг байна. Ийнхүү инфляци гаарах нөхцлийг бууруулдаг юм байна. Ж.Дэлгэрсайхан “Манай

орны хувьд ийм боломж хомс. Гэхдээ урт хугацаанд инфляцийг бууруулахын тулд үндэсний үйлдвэрлэлийг дэмжих хэрэгтэй. Тэгэхгүй бол үнийн өсөлтийг хүчээр барих нь эдийн засагт бүр л сөрөг үр дагавар авчирна” гэв.

Тиймээс бид эцсийн эцэст өөрсдөө хөдөлмөрлөж, үйлдвэрлэж байж л төгрөг “тамир тэнхээ” сууна. Инфляци буурна. Эдийн засаг тогтвортой өснө. ■

АСУУДАЛ

ХУВЬЧЛАЛЫГ ТАНДАХАД

С.ЗАЯА

Иргэн Дорж социализмын үед өсч, хүмүүжиж, мэргэжил эзэмшсэн нэгэн. 1990 он хүртэл бүх өмч төрийн мэдэлд байж, түүнийг хайрлан хамгаалах суртал ухуулгыг хийдэг байсан үеийг тэр сайн мэднэ. Одоо тэр хувьчлалыг цэнхэр ягаан тасалбараар төсөөлдөг. Ганц Дорж ч гэлтгүй Монголын ард түмний дийлэнх нь ардчилал гарсны дараа хувьчлал гэгчтэй танилцаж, өдгөө ч энэ зүйлийн үнэ цэнийг цэнхэр, ягаан гэсэн хоёр өнгөтэй тасалбараар төсөөлж, төлөөлүүлж бодож сууна.

Монголчуудын хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл одоо ч хомс. Тиймээс хувьчлал мөнгөтэй, эсвэл зальтай нөхдүүдийн хэтэвчийг зузаатгаж, нийгэмд баян хоосны ялгаа бий болгосон гэж үзэх, дүгнэх хүн олон. Гэхдээ хувьчлал эерэг, сөрөг олон зүйл авчиржээ. Тухайлбал, өнгөрсөн хугацаанд нийгмийн салбарт маш олон аж ахуйн нэгжийг хувьчилсан. Гэтэл хувьчилж авсан хүмүүс нийгэмд

төрийн үзүүлж байсан үйлчилгээг үзүүлэхээ болив. Монголын хүүхэд, залуучуудын театрыг хувьчилсны дараа өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Уг нь энэ театраар дамжуулж багачуудын сэтгэлгээ, үзэл бодолд эерэгээр нөлөөлдөг байв.

Мөн Азид дээгүүр бичигддэг байсан циркийг хувьчилснаар хөгжил нь зогсонги байдалд орсон гэхчлэн сөрөг жишээ олныг дурьдаж болно. Харин хувьчилсан ч үнэ цэнээ алдаагүй сайн ажиллаж буй компаниуд ч бий. “НИК”, “Говь”, “Мах импекс”, “АПУ”, “Дархан ▶



► нэхий” гээд нэрлэж болно.

Өмч хувьчлалын дараагийн давалгаа ирэх онуудад үргэлжлэх гэж байна. Үүнийг “Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төслөөс харж болох. Энэ талаар Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн удирдлагын газрын дарга Д.Болормаа “Одоо бид алдаанаасаа сургамж аваад хэн нэгний өмчлөлөөс илүүтэй хамтын үйлдлээр цаашид үйл ажиллагаагаа явуулах ёстой. Энэ нь эргээд зах зээлийн зарчмаар хөгжиж эдийн засагт хувь нэмрээ оруулж эхлэх нь хувьчлалын гол үр дүн юм. Анх хувьчлал явуулж байхад төрийн нэрийн өмнөөс аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх чадамжтай компаниуд цөөн байсан. Харин одоо төрийн өмчийн хувьчлал явагдах нөхцөл бүрдсэн” гэв.

Хувийн хэвшил тодорхой цаг хугацааны туршид хөгжөөд ирэхээр тухайн нэг салбарыг аваад явах чадамжтай болдог. Тиймээс үүнийг төр үүрээд байх шаардлагагүй гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, яамдын байр, зам харгуй, барилга зэрэг төрийн өмчийнхөө хадгалалт хамгаалалт, ашиглалт зэрэг бусад ажлаа төр хийгээд явах ёстой гэсэн байр сууринаас хувьчлалд хандаж буй аж. УИХ-д өргөн мэдүүлсэн тогтоолын төсөлд 22 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг хувьчлахаар тусгажээ. Ингэхдээ нээлттэй дуудлага худалдаа, хувьцаа гаргах, хамтарсан компани байдлаар хийж болох аж.

Ирэх онд эхний ээлжинд дөрвөн компани хувьчлах саналтай байгаагаа тогтоолын төсөлд тусгажээ. Үүнээс ирэх оны төсөвт 153 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгасан байна. Гэхдээ хувьчлах жагсаалтад орсон 22 аж ахуйн нэгжээс чухам алийг нь хувьд шилжүүлэхийг УИХ-ын энэ намрын чуулганаар шийдэх аж. Тухайлбал, МИАТ-ийн 49 хувийг дотоодын авиа компаниудад хувьчлах санал оруулаад байгаа. Эндээс төр үндэсний авиа компаниа хувийн хэвшилтэй хамтарч эзэмших нь эрсдэл дагуулах уу гэдэг асуулт гарч ирнэ. Үүнд Д.Болормаа

дарга “Хувийн хэвшлийн авиа компаниуд бүгдээрээ алдагдалтай ажиллаж байна. Учир нь, бүгд өөрсдөө газрын үйлчилгээг тус тусдаа явуулдаг. Тэгэхээр эдгээр компани хоорондоо нэгдвэл алдагдалтай ажиллахгүй. Дотоодын компаниуд алдагдалтай ажиллаж байхад манайд орж ирж буй гадны авиа компаниуд ашигтай ажиллаад байдаг. Яагаад гэвэл тэд бүрэн бойжсон, бэлэн зах зээлд орж ирж байна. Тиймээс бид үндэсний эв нэгдэлтэй байвал зах зээлээ өөрсдөө хамгаалаад яваад байх боломжтой” гэв.

Хувьчлах аж ахуйн нэгжийн жагсаалтад “Оргил” бидний нэрлэж заншсанаар “Улаанбаатар” сувилал / Уламжлалт анагаахын шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн корпораци/

Хувьчлах аж ахуйн нэгжүүдийн хэд нь Хөрөнгийн биржээр арилжаалагдах эсвэл сонгон шалгаруулалтаар худалдагдах уу гэдгийг УИХ хэлэлцүүлгийн явцад шийднэ.

багтаад буй. Нийслэлчүүд төдийгүй орон нутгийн иргэд дээрх сувиллуудад олноор хэвтэн эмчлүүлдэг. Үүнийг хувьд шилжүүлж, төлбөртэй болгосноор иргэд эрүүл мэндийн үйлчилгээ авахад хүндрэл учрахыг үгүйсгэхгүй. Энэ талаар холбогдох албаны хүн “Оргил” рашаан сувилал анх байгуулагдаж байхад цэвэр агаарын бүсэд байсан. Рашааныг дагасан уламжлалт анагаахын үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшил тухайн үед байгаагүй. Одоо үүнээс илүү үйл ажиллагаа явуулж буй сувиллууд хотын захгаар бий болсон байна. Хүн эрүүл агаарт байж уламжлалт эмчилгээ хийлгэх сонирхолтой байдаг юм байна. Бид “Оргил” рашаан сувиллаар үйлчүүлэгчдийн тоог харсан. Хувийн хэвшлийн өрсөлдөөн бий болсон учир хувьчлах жагсаалтад оруулсан. Харин манай эрүүл мэндийн даатгалын систем зөв байх ёстой. Төр үүнийг хүчээр бариад явах боломж алга. “Оргил”, “Улаанбаатар” сувилал үнэ

төлбөргүй үйлчлэхгүй байгаа. Төрийн өмчийнх гэсэн хэр нь иргэдээс байнга татаас авдаг. Улсын төсвөөс мөнгө аваад өөрсдөө аж ахуйн үйл ажиллагаа давхар эрхэлж байна. Тэнд төрийн нэрийг барьсан монополь үйлчилгээ явагдаж байна гэсэн үг” хэмээсэн.

Төрийн өмчийн хороо дөрвөн жилд нэг удаа хувьчлах аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг УИХ-аар батлуулдаг байсан. Одоо өмчийг олон нийтэд эзэмшүүлэх хэлбэрээр хяналтын тогтолцоо бүрдүүлж, зах зээлийн зарчмаар хөгжүүлэх тогтолцоо руу шилжүүлэхээр явж байгаа аж. Өөрөөр хэлбэл, хэн нэг этгээд ганцаараа тухайн өмчийг худалдаж авдаг бус олон хэлбэрээр хамтарсан эсвэл хувьцаа эзэмших хэлбэр рүү шилжүүлнэ. Өмч олон эзэнд очих хэрээр хяналтын тогтолцоо өндөр болж зах зээлийн зарчмаар хөгжинэ гэж үзэж байна.

Хувьчлалын алдаа, оноо аль ч улс оронд байдаг. Тиймээс ахиж алдахгүйн тулд Төрийн өмчийн хороо хувьчлах компаниудын менежмент, төлөвлөлт дээр ажиллажээ. Ингэхдээ компанийн өөрийнх нь өртгийг бууруулахгүйгээр хөрөнгө оруулалтыг хэрхэн зөв зохистой урсгалд оруулах вэ, боловсон хүчний чадавхийг яаж дээшлүүлэх үү гэдэгт анхаарсан байна. Учир нь технологи дагаад боловсон хүчин чадавхжих ёстой гэж үзжээ. Энэ ажлыг хийхээс өмнө хувьчлах дээрх 22 аж ахуйн нэгжид хөрөнгийн менежмент тааруу, их хэмжээгээр бараа бүтээгдэхүүн авч байжээ. Тухайлбал, 2012 онд 69 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан бол өнгөрсөн жилийн эцсээр энэ тоог 57 тэрбум төгрөгөөр бууруулж чадсан байна. Жилийн дотор алдагдлыг ийн бууруулж чадсан нь том амжилт. Анх удаа МИАТ компани ашигтай ажилласан аж.

Хувьчлах аж ахуйн нэгжүүдийн хэд нь Хөрөнгийн биржээр арилжаалагдах эсвэл сонгон шалгаруулалтаар худалдагдах уу гэдгийг УИХ хэлэлцүүлгийн явцад шийднэ. Уг нь нэг аж ахуйн нэгжийг монополь эрхтэйгээр ганц хүнд өгөх бус олон талын оролцоог хангавал хувьчлал гэх “боловсон луйвар” явагдахгүй. Гагцхүү үүнийг шийдэх хүмүүс нь хууль тогтоох байгууллагынхан болчихоод байна. ►

Бүрэн хувьчлагдах хуулийн этгээдүүд

1. “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компани болон “Багануур, Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийг өргөтгөх, техник, технологийг шинэчлэх, зардал бууруулах, үйлчилгээний шуурхай, найдвартай байдлыг хангах зорилгоор нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар үндэсний компанид хувьчлах;
2. “Цагаан шонхор” төрийн өмчит үйлдвэрийн газрыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах;
3. “Оргил рашаан сувилал” төрийн өмчит хувьцаат компанийг үйл ажиллагааных нь чиглэлийг өөрчлөхгүй нөхцөлтэйгээр нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах;
4. “Кино урлагийн дээд сургууль” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн хувьцааг бусад хувьцаа эзэмшигчдэд санал болгож, татгалзсан тохиолдолд нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах;
5. “Авто импекс” хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг бусад хувьцаа эзэмшигчдэд санал болгож, татгалзсан тохиолдолд төрийн эзэмшлийн хувийг хөрөнгийн биржээр дамжуулан арилжих;
6. “Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан арилжих;
7. “Монсам” төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн хувьцааг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах;
8. “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах;

Уламжлалт анагаахын шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн корпораци, Эрчим корпораци, Армоно корпораци болон Хөдөө аж ахуйн техникийн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийг үйл ажиллагааных нь чиглэлийг өөрчлөхгүй нөхцөлтэйгөөр оюуны өмчийн үнэлгээг харгалзан зөвхөн салбарын эрдэмтэн, судлаачдын багт хаалттай уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах;

Төрийн эзэмшлийн хувийг бууруулах хуулийн этгээдүүд

1. “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн бүтцийг өөрчлөн зохион байгуулж, нийт хувьцааны 34-өөс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, 66 хувийг үе шаттайгаар стратегийн болон санхүүгийн хөрөнгө оруулагч нарт санал болгох, хувьцааг Монголын хөрөнгийн бирж болон гадаадын нэр хүнд бүхий хөрөнгийн биржээр нээлттэй арилжих;
2. “Тариалан эрхлэлтийг дэмжих сан” /төрийн өмчит үйлдвэрийн газар/-г компанийн хэлбэрт шилжүүлж, компанийн 34-өөс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, 66 хүртэлх хувийг үе шаттайгаар хувьчлах;
3. “Хөдөө аж ахуйн бирж” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны 34-өөс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, 66 хүртэлх хувийг Монголын хөрөнгийн биржээр үе шаттайгаар хувьчлах;
4. “Монгол шуудан” төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээнд нэмэлт хувьцаа гаргаж, Монголын хөрөнгийн биржээр арилжих;
5. “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн 51-ээс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, 49 хүртэлх хувийг нээлттэй уралдаант шалгаруулалтаар хувьчлах;
6. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг 34 хувь байлгах хэмжээнд нэмэлт хувьцаа гарган хөрөнгө оруулагчдыг татах;
7. “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 34-өөс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, 66 хүртэлх хувийг энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд үе шаттайгаар хувьчлах;
8. “Шивээ-Овоо” хувьцаат компанийн төрийн эзэмшлийн 20 хүртэл хувьд ногдох хувьцааг Монголын хөрөнгийн бирж болон гадаадын нэр хүнд бүхий хөрөнгийн биржээр арилжих;
9. “Багануур” хувьцаат компанийн нийт хувьцааны 51-ээс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгах хэмжээнд нэмэлт хувьцаа гаргаж, Монголын хөрөнгийн биржээр арилжих.
10. “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компанийн 34-өөс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, 66 хүртэлх хувийг үе шаттайгаар хувьчлах ■

Эх сурвалж. Төрийн өмчийн хороо

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСЫГ ЯАГААД ХУДАЛДАН АВАХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Г.МӨНХ-ЭРДЭНЭ /Гаули ҮЦК-ийн хөрөнгө оруулалтын шинжээч/

Эрсдэлгүй хөрөнгө оруулалт

Засгийн газрын үнэт цаас нь эрсдэлгүй хөрөнгө оруулалт гэдэг утгаараа эрсдэлд дургүй хөрөнгө оруулагчдын хувьд хамгийн найдвартай сонголт байдаг. Гэхдээ үүний хэрээр өгөөж нь ч бас бага байдаг учир жижиг хөрөнгө оруулагчдын сонирхлыг төдийд татдаггүй.

Тэгвэл Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдан Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаас /ЗГЖҮЦ/-ыг анх удаа иргэддээ санал болголоо. Ингэхдээ өндөр хүү санал болгож байгаа нь богино хугацаанд эрсдэлгүй, өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт хийх боломжийг олгож байгаа юм.

Графикт Монголын хамгийн том дөрвөн банк, дунд хэмжээний гурван банкны хадгаламжийн сертификатын хүүг дундажлан ЗГЖҮЦ-ны хүүтэй харьцуулж харуулав.

Хүүгийн зөрүү хугацаа багасах тусмаа нэмэгдэж байгааг анзаарах нь хамгийн чухал. Тодруулбал, гурван сарын хугацаатай ЗГЖҮЦ-ны хүү хадгаламжийн сертификатын хүүнээс 4.1 хувиар илүү байгаа юм. Жишээ нь, хэрэв та 100 сая төгрөгөөр гурван сарын хугацаатай ЗГЖҮЦ худалдан авбал хадгаламжийн хүүгээс нэг сая орчим төгрөгийн хүү илүү хүртэнэ.

Хүү үргэлж өндөр байх уу?

Олон нийтэд зориулж арилжаалж байгаа үнэт цаас учир хадгаламжийн хүүгээс өндөр байх тусмаа хөрөнгө оруулагчдыг татна. Гэхдээ эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал нь хүүгийн зөрүүг 4.1 хувь хүртэл өсгөж байгаа бөгөөд эдийн засаг хэвийн нөхцөл байдалд орох үед хүүгийн зөрүү буурах нь гарцаагүй. Иймээс одоо санал болгож буй хүү цаашид удаан хугацаанд хадгалагдах боломжгүй юм.

Нийт үнэт цаасны арилжаалах хэмжээ 100 тэрбум төгрөг

ЗГЖҮЦ-ны арилжааг МХБ-ээр дамжуулан арилжаалж байгаа бөгөөд эхний ээлжинд 100 тэрбум төгрөг хүртэлх



хэмжээтэй үнэт цаас гаргах юм. Харин өнгөрсөн хоёр долоо хоногийн хугацаанд 4.7 орчим тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалаад байна. Цаашид үлдсэн үнэт цаасыг арилжаалах бөгөөд 100 тэрбум төгрөг гэдэг нь банкны салбар дахь 5.2 их наяд төгрөгийн хадгаламжтай харьцуулахад дөнгөж хоёр хувь юм.

Дараагийн арилжаа хэзээ вэ?

Гурван сарын хугацаатай ЗГЖҮЦ-ны арилжааны захиалгыг 2014.11.12 - 2014.11.18-ны өдрүүдэд авч арилжааг хийх юм. Бид цаашид арилжааны хуваарийг тогтмол мэдээллэж байх болно.

Боломжийг хэрхэн ашиглах вэ?

ЗГЖҮЦ-ны арилжаанд орохын тулд үнэт цаасны компанид данстай байх шаардлагатай. Монголын хөрөнгийн зах зээлд нийт 71 компани бүртгэлтэй байна. Хамгийн чухал нь таны сонгосон үнэт цаасны компани шийдвэр гаргахад шаардагдах хангалттай мэдээлэл, судалгаагаар хангаж, тодорхой зөвлөмж, саналыг гаргах өндөр түвшний мэргэжлийн ур чадвар, ёс суртахуунтай байх шаардлагатай. Мөн үнэт цаасны арилжааг хамгийн хурдан, найдвартай, шимтгэл багатай хийх боломжтой байх нь таны хөрөнгө оруулалтын үр дүнд нөлөө үзүүлнэ. ■

ЗОЧИН

АВСТРАЛИ ЭЛЧ

И.ОТГОНЖАРГАЛ

Лиззи ухаалаг бас хүчтэй эмэгтэй. Хэдийгээр түүний Монголд ажиллах хугацаа өнгөрөгч аравдугаар сарын эцсээр дуусаж, нутаг буцсан ч ийм үгийг түүнд зориулж хэлэхийг хүсэж байна.

2013 оны аравдугаар сарын 27. Манай “Mongolian Economy” сэтгүүлийн редакци нэгэн гадаад зөвлөх мэргэжилтнээр бүл нэмсэн өдөр.

Ганц манай байгууллага ч биш ажлын чанар, гүйцэтгэл, бүтээмж, менежмент, маркетинг гээд олон чиглэлээр гаднын туршлагыг нэвтрүүлж, өсөж дэвших хүсэл сонирхолтой Монголын салбар салбарын 20 гаруй байгууллагад Австралийн Засгийн газраас орон бүрт шилж сонгож илгээдэг AYAD хөтөлбөрийн шугамаар ээлжит шижигнэсэн залуусаа илгээсэн. Түүний нэг нь манай байгууллагад ажилласан. Бид ийм мэргэжилтэн авахын төлөө

байгуулагдсан цагаасаа зорьсон, хичээсэн. Хоёр жилийн дараа бидний хүсэл биелсэн нь энэ. Сэтгүүлийн маань гадаад хэлний редактор америк залуутай нийлээд манайх хоёр гадаад хүнтэй ажиллаж эхлэв.

Залуухан, эрч хүчтэй, энгийн даруу эмэгтэй нэг жилийн хугацаатай зөвлөх мэргэжилтнээр ажиллахаар манай редакцийн хаалгаар орж ирсэн тэр цаг хугацаа дөнгөж саяхан мэт. Гэтэл бүтэн нэг жил өнгөрчээ. Бид түүнийг ▶



нутаг руу нь үдэж гаргаад нэг сар болж байна. Нэрийг нь Элизабет Лиззи Хүү гэдэг. Түүнийг ирэхээс өмнө AYAD хөтөлбөрийг хариуцан хэрэгжүүлэгч Монгол дахь байгууллагын зүгээс уг шалгаруулалтад тэнцсэн манай байгууллагын хувьд баяр хүргэхийн сацуу гадаад мэргэжилтэн ажиллуулахад анхаарах зүйлсийн талаар бидэнтэй уулзаж, зөвлөмж өгч байсан. “Дулаан уур амьсгалтай орны хүн Монголын тэсгэм өвлийн улиралтай шууд золгож байгаа учраас даарч хөрөх, ханиад томуу хүрэх, хоол ундаа зохицуулах, орчин нөхцөлдөө дасахаас авахуулаад олон зүйл байдаг. Цаг хугацаа ч ордог. Та бүхэн үүнд анхаараарай” гэж. Үнэхээр ч Монголын утаатай, хүйтэн өвлөөс гадаад хүн битгий хэл, монголчууд бид өөрсдөө халгадаг учраас анх удаа гаднын зөвлөх мэргэжилтэн авч байгаа бидний хувьд өвдөж, зовчих вий гэж эмээж л байлаа. Азаар манай Лиззи Монголд байх хугацаандаа хамрын ханиад ч бараг хүрээгүй. Түүнтэй хамт ирсэн бусад найз нөхөд нь ханиад хүрсэн, гэдэс дотор нь хямарсан л дуулддаг. Тэрбээр Монголд монгол хүн шиг амьдарсан. Монголд монгол хүн шиг дасан зохицож амьдардаг гадаад хүмүүс бий л байх. Гэхдээ Лиззи бусдаас өөр.

Австралийн засгийн газартай гэрээ хийж, өндөр үүрэг хариуцлага үүрч ирсэн эмэгтэй. Тиймээс ажлаа ч сайн хийж, амралт зугаалгаар Улаанбаатар хотын ойролцоох Монголын үзэх ёстой үзэсгэлэнт газруудаар аялж, монгол хоол идэж, өвөл нь даарч, хаврын хавсрага салхинд “гундаж”, зун нь халууцаж, налгар намрыг үзэж, дахин өвөл айлчлахын өмнөхөн нутаг буцсан. Ингэхдээ өвдөж, эсвэл амин хувийн ажил амжуулна гэж ажлаас чөлөө авсан ганц ч өдөр байхгүй. Тэрбээр спортоор хичээллэдэг, бие бялдрын хөгжил сайтай болоод ч тэр үү Монголын хатуу, ширүүн уур амьсгалд амархан дасан зохицож, биеэ зөв авч явсан. Лиззи “Гадаад хүмүүст тухайн оронд очиж ажиллаж, амьдрахад янз бүрийн зүйлийн талаар хүлээлт өндөр байдаг. Миний хувьд байгаа зүйлийг байгаагаар нь хүлээж авч, ажил амьдралаа жигд явуулсантай холбоотой” хэмээн Монголд дасан зохицож, амжилттай ажилласан талаараа товч, тодорхой хэлж байсан.

Мөн миний 2009-2011 онд Японд ажилласан туршлага Монголд ажиллах шалгаруулалтад тэнцэхэд минь нэмэр болсон байх гэж сонирхуулсан.

Бизнес, маркетингийн үндсэн мэргэжилтэй ч Лиззид хэвлэл мэдээллийн байгууллагад хийж чадахгүй гэж төвөгшөөх ажил байгаагүй. Нийтлэл бичиж, редактор хийж, хэвлэлийн зөвлөх, график дизайнераар ч ажиллах чадвартай. Маркетингийн чиглэлээр бол бүр их авьяас, туршлагатай нэгэн гэдгийг бид цаг хугацаа өнгөрөх тусам мэдэрч байлаа. Эдгээрийн

Манай сэтгүүлийн бие даасан, хараат бус байдал түүнд тун таалагдсан. Тийм ч учраас тэрбээр биднийг энэхүү хараат бус байдлаа цаашид хэрхэн хадгалах, олон улсын бие даасан редакцийн бодлого, стандартыг мөрдүүлж, хэвшүүлэх ажилд нэлээд анхаарсан.

аль алинаар нь Австралидаа сурч, ажилласан туршлагатай. Зөвхөн нэг мэргэжлээр дагнаад явах биш, хөрвөх чадвартай ийм мэргэжилтнүүд Монголд, тэр дундаа хувийн хэвшлийн байгууллагуудад өнөөдөр маш хэрэгтэйг тэрбээр бидэнд улам бүр мэдрүүлсэн.

Сэтгүүл зүйн гал тогоонд мэндлээд гурван жил гаруйн хугацааг үдэж буй манай байгууллагын хувьд Лиззи маань олон зүйлийг хийж, шинэ шинэ ажлын үндэс суурийг тавьсан. Шинэхэн байгууллагад ажиллахад түүнд өөрт нь ч бодсон санаснаа хийж хэрэгжүүлэх, туршлага мэдлэгээ нэвтрүүлэхэд амар байсан биз ээ. Ялангуяа манай сэтгүүлийн бие даасан, хараат бус байдал түүнд тун таалагдсан. Тийм ч учраас тэрбээр биднийг энэхүү хараат бус байдлаа цаашид хэрхэн хадгалах, олон улсын бие даасан редакцийн бодлого, стандартыг мөрдүүлж, хэвшүүлэх ажилд нэлээд анхаарсан. Бидэнд

ч энэ чиглэлээр түүнээс сурсан мэдсэн зүйл багагүй бий. Түүнчлэн манай гадаад хэлний редактортой, сэтгүүлийн эх бэлтгэгчтэй, сэтгүүлч нартай, удирдлагуудтай тулж ажиллаж, үе шаттай сургалтууд хийсэн. Тухайлбал, манай сэтгүүлийн хавтасны дэглэлтээс эхлээд өөрчлөлт шинэчлэл явагдаж байгааг захиалагч, уншигчдын маань зарим нь анзаарч, талархлаа илэрхийлж байх жишээтэй. Энэ бол Лиззигийн сургалтын үр дүн. Энэ мэт манай хамт олонд цаашид хөгжүүлж үр дүн гаргах олон зүйлийг харамгүй хэлж, зааж өгсөн Австрали зөвлөх мэргэжилтэн Элизабет Лиззи Хүүд баярлалаа. Түүний хувьд ч Монголд ажиллаж амьдарсан нэг жил нь их хувь зохиол болсон нь мэдээж. Тэрбээр Монгол орны хөгжил дэвшлийн талаар хэлэхдээ “Ажлын байр зарлах, ажилд орохоор ирж байгаа залуусын жишээнээс харахад л Монголын залуучууд ямар их боловсрол мэдлэгтэй юм бэ гэдэг нь харагддаг. Залуучууд 2-3 гадаад хэл эзэмшсэн, гадаадын 2-3 их, дээд сургуульд суралцаж, төгссөн байдаг. Энэ бол үнэхээр бахархалтай. Боловсрол мэдлэгээр ийн зэвсэглэсэн залуустай Монгол Улсыг хөгжинө гэдэгт би итгэлтэй байдаг” хэмээсэн. Тиймээс Лиззи маань өөрчлөлт маш хурдтай явагдаж байгаа Монгол орны таван жилийн дараах хөгжлийг харахаар манайд дахин ирэхээ бидэнд амласан. Мөн тэрбээр өөрийн залуу насныхаа хөдөлмөр, эрч хүчээс шингээсэн “Mongolian Economy” сэтгүүлээ таван жилийн дараа ямар болсныг харах хамгийн сэтгэл догдлуулсан мөч байх болно гэдгийг ч догдлол тээн ярьсан. Тиймээ, тэр Монголд ирж чадна. Бид ч түүнийг ирэхийг тэсэн ядан хүлээнэ. Таван жилийн дараа Лиззитэйгээ уулзана. Манай редакци ч илүү өргөжиж чадавхжсан, олуулаа болсон байна гэдэгт итгэлтэй байна.

Гэр бүл ч зохиож амжаагүй залуухан чи минь насандаа ахадсан ухаалаг, хүчтэй, мэдрэмжтэй, бас гадаад хүн гэхэд дэндүү эгэл даруухан эмэгтэй. Цаашдын ажил амьдралд нь аз жаргал, эрүүл энхийг хүсье. Ирэх таван жил чиний ч, бидний ч хувьд хүлээх догдлолтой, хүсэх зорилготой, хүрэх оргилтой байх болно, баярлалаа чамд. ■



Д.Жаргалсайхан: МН
группийн ерөнхийлөгч

ҮЗЭЛ БОДОЛ

ТУЛГЫН ГУРВАН ЧУЛУУНЫ ЗАГВАР

Нийгмийн өмнө тулгарсан олон асуудал иргэдийг бухимдуулж, тэдгээрийг шийдвэрлэх арга замын эрэлд хэн хүнгүй л гарчихаад буй. Миний бие ч гэсэн нийгмийнхээ нэг эд эс нь болохоороо бас санаа нэмэрлэх ёстой хэмээн энэхүү нийтлэлийг зориг гарган мутарлав.

“Тулгын гурван чулуу шиг туждаа хамт явах юмсан” ... гээд бид дуулдаг. Тулгын гурван чулуу гэхээр монгол хүний дотор юуны түрүүнд ахуй амьдралд маань хэзээд хэрэг болдог түшиг тулгуур, суурийн тухай санаа буудаг. Түүний дараа аливаа юмыг түшихэд, тулахад хэрэг болдог түшиг тулгуурын тэнцвэртэй байдал, суурийн бат бэх байдал санаанд ордог. За тэгээд гурав гэдэг тоонд бас их томоохон философи агуулагдаж байдаг юм уу даа. Хүн орчлон хорвоог, амьдралыг ойлгохын тулд яах ч аргагүй хэмжээс, шалгуур бий болгосон. Халуун, хүйтэн, урт, богино, хурдан удаан, өнгөрсөн цаг, ирээдүй цаг, зовлон, жаргал гэх мэтээр дурьдаад байвал дуусахгүй. Энэ олон, хязгааргүй хэмжээсээр орчлон хорвоог танихын тулд хүн өөртөө ойлгомжтой тоолуурын эхлэл цэгийг бий болгох зайлшгүй шаардлагатай тулгарсан. Жишээлбэл, ус шингэн төлөвөөс хатуу төлөвт шилждэг хэмийн / температурын / төлөв байдлыг тэг / О / градус гэж, Есүс Христийн төрсөн жилийг цаг хугацааны тооллын эхний тоолуурын цэг болгож авсан байх юм. Танин мэдэхүйн шаардлагын үүднээс бий болгосон дээрх хэмжээсийн тогтолцоо нь ийнхүү гурван үндсэн

төлөв байдлаас бүрэлдэх болжээ. Нийгмийн амьдралыг танин мэдэх, тэрхүү мэдлэгээ амьдралд хэрэглэхэд мөн л гурван төлөв байдлын хэмжээс хэрэгтэй. Ялангуяа нийгмийн баялаг, нөөц боломж цаг хугацаанд хэрхэн шилжин, өөрчлөгдөж байгааг шинжиж судалж, зүй тогтлыг нь танин мэдэх нь маш чухал бололтой.

Аливаа нийгэм оршин тогтож байна гэдэг тэрхүү нийгэм тэнцвэртэй нөхцөл байдлын төлөвт байгаа гэсэн үг юм. Тэгвэл тэрхүү тэнцвэр юун дээр тогтож байна вэ? Түших тулах юм байна л гэсэн үг. Тэгвэл тэр тулгуур нь юу юм бэ гэдэг асуулт өөрийн эрхгүй гарч

тогтнох мөн өсөн дэвжих их үйлсийн загварыг заах мэт. Учрыг доор өгүүлье.

Хүн төрөлхтний түүх бол хүмүүс хоорондын тэмцлийн түүх. Тэмцэлд хэнийг дайсан, хэнийг нөхрөө гэж үзэхэд тодорхой шалгуур хэрэгтэй. Тийм ч учраас аливаа нийгмийг бүрдүүлж буй хүн амыг ангилдаг олон шалгуур, ангилал хүн төрөлхтөн бий болгож амжсан. Арьс өнгө, шашин шүтлэг, гарал угсаа, хөрөнгө чинээ, хэл ус, соёл, үзэл бодол гээд мөн ч олон шинж тэмдгээр хуваагдана даа. Түүгээрээ бие биенээ ялгаварлана, хоорондоо нанчилдана, дайтана, нэгнээ хөнөөнө. XX зууны жишээнээс

Аливаа нийгэм оршин тогтож байна гэдэг тэрхүү нийгэм тэнцвэртэй нөхцөл байдлын төлөвт байгаа гэсэн үг юм. Тэгвэл тэрхүү тэнцвэр юун дээр тогтож байна вэ? Түших тулах юм байна л гэсэн үг. Тэгвэл тэр тулгуур нь юу юм бэ гэдэг асуулт өөрийн эрхгүй гарч ирнэ. Энэ асуултад өгөх хариултын эрэл манай монголчуудын сайн мэдэх тулгын гурван чулууны тухай ойлголт руу хөтөлсөн юм.

ирнэ. Энэ асуултад өгөх хариултын эрэл манай монголчуудын сайн мэдэх тулгын гурван чулууны тухай ойлголт руу хөтөлсөн юм. Тулгын гурван чулуу бол тэнцвэртэй, тогтвортой байх, бас тэнцвэртэй, тогтвортой байлгахын билгэдэл, загвар юм. Энэхүү энгийн мөртлөө аугаа философийг агуулж буй Монгол түмний маань өргөн хэрэглэдэг ойлголт та бидний ирээдүйд оршин

харахад л хүмүүс хөрөнгөтэй, хөрөнгөгүйгээрээ талцаж нэг хэсэг биенээ хядаж, хүйтэн дайныг оролцуулаад дэлхийн хэмжээний гурван ч дайн гарч дайтаад амжив. Тэгээд ямар ч шинж тэмдгээр ялгарч, талцаж хуваагдсан бай эцэст нь үр дүн нь нийгмийн нөөц боломжийг хуваарилах, захиран зарцуулах тал дээр л өөрчлөлт гардаг. Захиран ▶



Шог зургийг А.Амарсайхан

▸ зарцуулах, хуваарилах эрхийг эдэлж байгаа тал ямар ч сайхан арьсны өнгөтэй байсан, удам угсаа, ямар ч сайхан шашинтай, ямар ч их хөрөнгөтэй байсан ялгаагүй тийм эрхийг хүсэмжлэх нөгөө хэсгийнхээ эсэргүүцэл тэмцлийн улмаас доройтож дараагийн тэмцлээр дарагдан мөхнө. Хүн нийгмийн боломжоос хүртэх эрх нь ерөөсөө арьсны өнгөнд, аль эсвэл шашинд, гарал үүсэлд байгаа юм биш. Хүн бүр хүн шиг явах эрхтэй төрдөг юм байна гэх ойлголт түгэх болжээ.

Тэгвэл хүн төрөлхтний түүхийг нөөц боломжийн төлөөх тэмцлийн түүх гэж үзэж болох мэт. Хүний нийгмийн хөгжлийн олон шат дамжлага бүр өөр өөрийн онцлогтой ч нийтлэг шинж чанар бас ажиглагдаж байна. Аль ч нийгмийн үед нэг хэсэг нь нийгмийн нөөц, боломжоос гишүүдийнхээ дийлэнх олонхид хүртээмжтэй хүртээхийг шаарддаг /цаашид хүртээмжийнхэн гэж нэрлэе/ байхад нөгөө хэсэг нь нийгмийн нөөц боломжийг /цаашид боломжийнхон гэж нэрлэе/ тухайн гишүүний бүтээсэн хэмжээгээр хуваарилахыг шаарддаг. Энэ хоёр хандлага хоорондоо байнга

зөрчилдсөөр ирсэн.

Хүний нийгэм анх бий болсон цагаасаа эхлээд л дээрхи зөрчилдөөнийг хүчирхийлэлгүйгээр шийдчихдэг тогтолцоог бий болгох мөрөөдөлдөө хөтлөгдөж мөн ч олон засаглалын хэлбэрийг бий болгосон, Иргэд битгий хэл улс орнууд бий болгосон тогтолцооныхоо золиос болон алга болсон түүх бий. Нийгмийн нөөц боломжоос аль болох их хүртэх эрмэлзэлдээ захирагдан дээрх бүлгүүдийн аль аль нь хүчирхийллийн аргыг хэрэглэхээс буцдаггүй. Тийм ч учраас хүчирхийллээс өөрсдийгөө хамгаалах хүсэл хэрэгцээндээ захирагдаж Төр хэмээх институцийг бий болгосон. Иргэд өөрсдийгөө, өөрсдийнхөө өмч хөрөнгийг бусдын хүчирхийллээс хамгаалуулах сэдлээр Төр оршин тогтнохыг хүлээн зөвшөөрсөнтэй адил Төр нийгмийн гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалахын тулд хүчирхийлэл хийх эрхийг нь мөн хамтад нь хүлээн зөвшөөрдөг юм байна. Энэ хүчирхийлэл хийх эрхийг хүлээн зөвшөөрөх нь энгийн ойлгомжтой мэт боловч тэрхүү эрхээ Төр нь нийгмийн гишүүдийгээ захиран дарангуйлах

зорилгоор хэрэглэхээс сэргийлэх баталгаатай шийдлийг хүн төрөлхтөн өнөөг хүртэл олоогүй л байна. Чухам ийн учраас энэхүү институци нь нийгмийн гишүүдийг бусдын хүчирхийлэлээс хамгаалах нь битгий хэл өөрөө нийгмийн гишүүдийн зарим нэг хэсгээс нөгөө хэсгээ дарангуйлан захирах, хүчирхийлэх хэрэгсэл болсон. Энэ нь олон улс орны түүхэнд элбэг тохиолдсон төдийгүй 21-р зуунд ч Төр нь дарангуйлал, хүчирхийллийн хэрэгсэл, зэвсэг болсоор байна.

Төрийг сайхан төгсгөлтэй үлгэрт ард олноо жаргааснаар гардаг сайн хаан шиг болгох гэсэн оролдлого хүний нийгмийн түүхэнд олонтаа гарч байсан. Цаашид ч энэ эрэл эцэс төгсгөлгүй үргэлжлэх төлөвтэй. Шашины үзэлдээ суурилан сайн засаглал тогтоох гэсэн оролдлого бүтэлгүйтэв. Арьсны өнгө, шашин шүтлэг аль эсвэл яс үндэстний ялгаанд суурилсан засаглал урт насгүй гэдэг нь тодорхой болов.

Төр нь иргэдээ хөрөнгөтэй, хөрөнгөгүйгээр нь ялган барууны эсвэл зүүний хэмээн талцаж тэднийг хооронд нь зөрчилдүүлж, хагаралдуулж хэсэг туршилт хийв. ▸

► Төрийн дарангуйллаар бусдыгаа захирч, түүгээрээ өөрсдөдөө давуу байдал олгож талцдаг хэсэг нь ноёлдог байсан нийгэм тухайн нийгмийнхээ нөөц боломжоос хүртэж чадахгүй байгаа хэсгийнхээ байнгын тэмцэл, сөргөлдөөний улмаас нуран унав. Улмаар нийгмийн боломжоос ахиухан хүртээж, хуваарилахыг шаарддаг хэсгийг төлөөлсөн Төр бий болж хөрөнгө мөнгөтэй, ажилтай, овсгоотой хэсгийгээ золиосолж нэг үзээд бас л барсангүй.

Ийнхүү хүний нийгэм мөнхийн гурван тоглогчтой болсон. Одоо ч байгаа, цаашид ч энэ гурван гол оролцогчид байсаар байх шинжтэй.

Хүн төрөлхтний урт хугацааны түүхээс харвал эдгээр гурван оролцогчид хоорондын харилцаа хэр тогтвортой, тэнцвэржсэн байх вэ гэдгээс шалтгаалан тухайн улс, нийгэм оршин тогтнох, мандан бадрах, бууран доройтох нь хамаарч байгааг ажиглаж болно. Хүн бүр өөр өөрийн онцлогтой, хүн бүр өөр хоорондоо адилгүй болохоор тэдний хийж, бүтээж чадах зүйл бас харилцан адилгүй байх нь ойлгомжтой.

Хүн төрөлхтний урт хугацааны түүхээс харвал эдгээр гурван оролцогчид хоорондын харилцаа хэр тогтвортой, тэнцвэржсэн байх вэ гэдгээс шалтгаалан тухайн улс, нийгэм оршин тогтнох, мандан бадрах, бууран доройтох нь хамаарч байгааг ажиглаж болно. Хүн бүр өөр өөрийн онцлогтой, хүн бүр өөр хоорондоо адилгүй болохоор тэдний хийж, бүтээж чадах зүйл бас харилцан адилгүй байх нь ойлгомжтой. Адаглаад л нэг айлын, нэг эцэг эхийн хүүхдүүд хүртэл хоорондоо харилцан адилгүй байдаг. Ийм учраас хүн бүр өөрийнхөө хийж бүтээсэн хэмжээгээрээ нийгмийн нөөц боломжоос хүртдэг байх нь шударга ёсонд нийцэж байгаа мэт.

Гэтэл өөрийн болон нийгмийн тогтолцооноос хамаарч нийгмийн нөөц боломжоос хүртэж чадахгүй, наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа хэсэг байна. Тэд бол нийгмийн нөөц боломжоос хүртэх эрхтэй байхыг шударга ёс гэж үзнэ. Ингээд хоёр тал хоёулаа шударга ёсыг тогтоохын төлөө гэдэг ариун уриатай болж “нанчилдаж”

өгнө дөө. Түүнийг хувьсгал, дайн, төрийн эргэлт, бослого, жагсаал цуглаан хэмээн нэрлэх.

Гэтэл бас ч үгүй урт хугацаанд оршин тогтноод уналгүйгээр тэсээд байгаа нийгмийн тогтолцоонууд байна. Хэдийгээр тэдгээр нийгмүүдийн хэлбэр нь өөр хоорондоо ондоо, элдэв өөрчлөлтүүдийн давалгааг ажрахгүй оршин тогтноод байгаагийн дотоод учир шалтгаан нь ялгаатай ч тэднийг нэгтгэж байгаа хэв шинж нэг байна. Энэ нь аливаа шинэ бий болсон нөхцөл байдалд дасан зохицох чадвар юм уу даа. Энэхүү чадвар л байхгүй бол нийгмийн тогтолцоо, коммунист, капиталист, дарангуйлагч, хаант, бүгд

найрамдах, бүгд дайсагнах гээд ямар ч нэр, дарга, үзэлтэй байсан ялгаагүй мөхөн унах тавилантай. Шинээр бий болсон нөхцөл байдал гэж юуг хэлээд байна вэ?

Энэ бол даяарчилалын үйл явц, геополитикийн бодлогын өөрчлөлт, дэлхийн цаг агаар, хүрээлэн байгаа орчны өөрчлөлт, технологийн дэвшил, хүн амын өсөлт, түүний хэрэглээний өөрчлөлтийн давалгаагаар бий болж буй шинэ сорилт, шийдлээ хүлээж буй асуудлууд юм. 200 гаруй жилийн түүхтэй Америкийн ардчилсан нийгэм аль эсвэл хагас зуун жилийн настай Хятад дахь коммунист засаглалыг унана гээд, эсвэл хөгшин Европын тогтолцоог мөхнө, сүйрнэ хэмээн зөгнөж, элдэв янзын онол, таамаг дэвшүүлсэн ном, бүтээлүүд интернэтээр дүүрэн байна. Тэгвэл тэдгээр нийгмийн тогтолцоо оршин тогтносоор байгаагийн учир юунд байна вэ?

Яагаад, юуны учир ХХ зууны дэлхийн хамгийн том Коммунист хоёр орны

хувь заяа өнөөдөр хоёр янзаар эргэсэн байна вэ?

ЗХУ. Нийгмийн нөөц боломжийг тэгш хүртээж хуваарилах зарчимд суурилсан коммунист үзэл суртлыг бодитойгоор, хүчээр амьдралд хэрэгжүүлж манлайлагч болж өөрсдийн үзлээ бусдад тулгадаг болсны харгайгаар аливаа амьд организмд байдаг өөрийн сул талаа олж тогтоох, засаж залруулах чадвараасаа сайн дураараа хагацсан. Дээр нь дэлхийд хамгийн олон хүний амь насыг авч одсон дайнд хамгийн олон иргэнийхээ амь насыг золиослон байж ялсан нь тэр их гүрний удирдагчдын төдийгүй иргэдийн нийгмийн сонор сэрэмжийг алдагдуулсан биз ээ. Нийгмийн нөөц боломжийг оновчтой, үр ашигтай зарцуулж баялаг бүтээдэг хэсгээ хөөн зайлуулж, устгаснаар хөдөлгүүргүй хөлөг онгоц адил болж нөөц боломжоо хуваарилсаар сүүлдээ төрийн албан тушаалаас өөр хуваарилах ч нөөцгүй болов. Нийгмийн тулгын гурван чулууны нэг нь дутаж, ЗХУ нуран унав.

БНХАУ. Нийгмийн нөөц боломжийг хүртээж хуваарилах ёстой хэмээх үзэл суртлаараа ЗХУ-тай ижил боловч дэлхийд ноёрхох сурталтай, зэр зэвсэг, хүчирхэг армитай ЗХУ-аас байнга учруулж байсан дарамт, аюул занал, мөн ЗХУ-тай үзэл суртлаар өрсөлдөж мөн л хүчирхэг зэр зэвсэг, армитай АНУ болон түүний холбоотнуудын зүгээс учруулж байсан өрсөлдөөн, заналхийлэл болон дотоод эдийн засгийн хүндрэлүүд нь БНХАУ-ын удирдлагын сонор сэрэмжийг байнгын өндөр түвшинд байлгаж, улмаар цаашид оршин тогтнох арга замаа байнга өөрчилж шинэчлэх шаардлагыг бий болгосон бололтой. Ийм ч учраас ЗХУ хэмээх аварга том гүрэн нуран унаснаас хойш БНХАУ нуран унасангүй. Харин ч улам хөгжин тэлж, улмаар улс төр, эдийн засгийн асар хүчирхэг гүрэн боллоо. Үүний зэрэгцээ энэхүү коммунист гүрний нуран унахыг мөрөөдөгчдийн итгэл найдвар улам бүр замхарсаар.

Нийгмийн нөөц боломжийг хамгийн оновчтой ашиглаж үнэ цэнийг бүтээдэг хэсгийг дахин бий болохыг хүлээн зөвшөөрч нийгмийнхээ нөөц боломжийг нэмэгдүүлж чадсанаар дутагдаж байсан тулгуураа бий болгож ►►

► мөхлөөс зайлж чадав. Гэсэн хэдий ч олон том сорилттой нүүр тулсан хэвээр л байна. Нийгмийн тулгын гурван чулуу нь нийгмээ тулж чадаж байна, гэвч энэ тулгуур хэр тогтвортой, тэнцвэртэй байх бол.

Тэгвэл Барууныхан гэж бидний нэрлэдэг ертөнцөд юу болж байна ?

АНУ. Хүн бүрд ижил тэнцүү боломжийг олгосон нийгмийн тогтолцооны жишиг. Ядуу хоосон хүнд хэцүү амьдралыг туулж улс төр, бизнесийн өндөрлөгт гарсан түүх, амьд жишээ олонтой. Билл Геитс, Барак Обама, Зукерберг гээд олны танил болсон хүмүүсийн түүх бол тэдний амьд нотолгоо. Түүгээрээ ч тэд бахархдаг. 2009 онд АНУ-д эхэлж улмаар дэлхийн эдийн засгийг сүйрлийн ирмэгт аваачсан санхүүгийн системийн хямралын улмаас ардчилсан нийгмийн тогтолцоонд итгэх итгэл ганхаж, АНУ-ыг нуран унахыг хүсэн хүлээгчдэд итгэлийн оч найдвар төрөв. Нийгмийнхээ гишүүдийн эрхийг дээдэлдэг нийгмийн суурь тогтолцоотой АНУ-аас өөр ямар ч улсад тийм хэмжээний гамшиг нүүрэлсэн бол тэр улс орон задран унаж оршин тогтнохоо больсон байх биз ээ. Харин АНУ-ын аварга том нийгэм өөрийнхөө өвчин эмгэгийг оношлож, улмаар илааршуулах чадвартай болохоо батлан харуулж, эдийн засаг нь тогтвортой өсөх хандлагатай боллоо. Хүний эрхийг дээдэлдэг үзэл баримтлалаа огоорч эд мөнгийг амьдралын гол зорилго, хэрэгсэл болгосноор тулгын гурван чулууны тэнцвэр алдагдсан байлаа. Тэнцвэрийг дахин бий болгох нэр их аянд мордов.

Европ. Далайн чанадаас халдварласан санхүүгийн хямрал, хэрээс хэтэрсэн нийгмийн халамжийн бодлогоо даахгүй “өвдөж” улмаар мөхлийн ирмэгт очсон мэт байсан нь саяхан. Дээр нь хөгжиж байгаа орнуудаас хямдхан авдаг байсан түүхий эдийн үнэ ихээхэн өссөн нь нэрмээс болсон биз. Ийм том сорилтыг даахгүйгээр Европын холбоо задрана, нэгдсэн мөнгөн тэмдэгтэй байхаа болино гэсэн таамгууд ар араасаа гарч байлаа. Тэгтүл тэсээд гарлаа. Ямар нэг хүчирхийлэл, үймээн самуун аль ч гарсангүй. Яагаад ? Нийгмийн болох, болохгүй бүхий л

асуудлаа нээлттэй ил тод ярилцдаг, зөвшилцдөг, шийддэг нь тэр нийгмийн хамгийн том давуу тал юм. Үүнийхээ үр дүнд гаргасан алдаагаа залруулж, алдаа давтагдахгүй байх хамгаалалт, дархлаагаа бий болгож чадлаа. Хүртээмжийнхний бүлэгт таалагдах гэсэн төрийн популист бодлогын улмаас нийгмийн гол хөдөлгүүр болсон баялаг бүтээгчдийн суурь ганхаж, улмаар ЗХУ-ын хувь заяаг давтан алдав.

Хөгшин Европын улс болгонд нөхцөл байдал өөр өөр байгаагийн дотор Монголд үлгэр жишээ болж чадах хэд хэдэн загварууд байгааг бас нэмж хэлэх нь зүйтэй. Үүнд би Скандинавийн орнууд болон Швецарийг хамруулан ойлгож байгаа юм. Нийгмийн нөөц боломжийг байнга өсөн нэмэгдүүлж, түүнийхээ боломжинд тохирсон нийгмийн хуваарилалтын тогтолцоог бий болгож чадсан нь тэдгээр орны тогтвортой хөгжлийн суурь болжээ.

Зөвлөлт гүрний буурин дээр шинээр бий болсон улс орнуудад байдал ямар байна вэ ? Эдгээр оронтой бид өөрсдийгөө байнга харьцуулж байх нь нэн ашиг тустай санагдана. Учир нь бид ижил төстэй гараанаас өөр өөрийн жороор тодорхойлсон замаар замнаж байгаа билээ. Тэдний гаргасан алдаа, олсон амжилт бүрийн учир шалтгааныг мэдэж байх нь монголчууд бидний хувьд маш үнэ цэнэтэй сургажм боллох юм. Тэдгээр орноос Казахстан зэрэг зарим орон нь эдийн засгийн тогтвортой өсөлтөө хангаж чадсан боловч Тажикстан, Туркменистан гэх мэт орнууд эдийн засаг, улс төрийн хувьд хаалттай, дотоод зөрчил ихтэй, төрийн эрх барьж буй бүлгийн дарангуйллын тогтолцоо руу орсон. Эдгээр орны аль алинд нь Ерөнхийлөгч нэртэй дарангуйлагчийн тогтолцоо нэгтэй баттай бэхжиж нийгмийнхээ аливаа өвчин эмгэгийг мэдрэх чадвар, дархлаа нь үгүй болж хөгжил нь хэдэн арван жилээр хоцорчээ.

Төрийн эрх мэдлээр зэвсэглэсэн давхарга өөрсдийн ашиг сонирхлын төлөө нийгмийн бусад хэсгээ дарангуйлан өөрсдөдөө үйлчлүүлж байгаагаас тулгын гурван чулууны хоёр нь түшиг тулгуур болохоо нэгэнт өнгөрчээ.

Монгол улсынхаа түүхийн тодорхой үе шатуудыг аваад үзье. Хүний нийгмийн янз бүрийн засаглалын хэлбэрүүдийг дамжин өнгөрдөг бусад улс орны адил хаант төр, коммунист засаг гээд нэг хүнээс хамааралтай, түүний эрх ашигт үйлчилдэг нийгмийн байгууллын аль алийг нь өөрийн онцлогтойгоор туулан өнгөрүүлсэн. Монголын их эзэнт гүрний үед ч, Манжийн төрийн үед ч, коммунист засаглалын үед ч төр нь иргэдийн амьдралд шийдвэрлэх үүрэгтэй оролцож ирсэн. Хамгийн сонирхолтой нь эхний тохиолдолд нийгэм нь баялаг, нөөц боломжоо нийгмийн бүх гишүүдийн оролцоотойгоор бусад улс орон, иргэдийг байлдан дагуулалт хэмээх хүчирхийлэлийн аргаар албадан хөдөлмөрлүүлж бий болгож, өсгөн нэмэгдүүлж байсан бол Манж гүрний үед өөрийн төр ч гэж байхгүй байлаа.

Монголын эзэнт гүрэн, дараа нь Манж гүрэн, дараа нь коммунист засаглал гээд монголчууд бид хэдэн зуун жил төрийг дээдэлсэн, төрийг тахьсан нийгэмд амьдарч ирсэнийх юм уу өнөө хүртэл монголчуудын оюун санаанд нийгмийн гишүүдийг захирдаг, бүхний өмнөөс шийдвэр гаргадаг төрийн дүр төрх баттай оршсоор л байна.

Гадаадын оронд улс төрийн намуудын хоорондоо ялгарах гол ялгаа нь нийгмийн нөөц, боломжоос иргэд хэрхэн хүртэж байвал зохих талаарх тэдгээрийн байр суурь байдаг. Улс төрийн намууд нь үзэл бодлоороо уралдаж, төрийн эрхийг тодорхой хугацаанд барих эрх, мандатыг иргэдээсээ авдаг нь чухамдаа бол нийгмийн нөөц боломжийг хуваарилдаг тухайн үеийнхээ тогтолцоог улам боловсронгуй, тэнцвэртэй болгох арга замуудын талаар ухаан бодлоо уралдуулж, улмаар хэрэгжүүлэх эрхээ олж авч буй хэрэг. Зүйрлүүлж хэлбэл цагийн эрхээр тулгын гурван чулууны тэнцвэр алдагдсаныг засаж залруулж байгаа мэт.

Тэгтүл Монголын улс төрийн намуудын бодлогод төрийн оролцооны талаар тусгасан бодлого нь хоорондоо зарчмын ялгаагүй, тэр ч бүү хэл заримд нь энэ талаар бодлого гэж нэрлэгдэх юм алга байх юм. Тийм учраас сонгууль болох бүрд улс төрийн намууд төрийн эрхэнд ►

► гарахаараа төрийн эрх мэдэлд дулдуйдан хийх элдэв гоё үгээр далдалсан хөтөлбөрөөр уралддаг, бид ч тэрэнд нь хууртдаг. Төрийг удирдах үйл хэрэгт шууд оролцох эрхийг Үндсэн хуулиар иргэнд олгосон байтал өөрсдийгөө нам, намын гишүүн гэж гоёж гоодсон бүлэг хүмүүс удирдах эрх эдлээд иргэдийн эрхийг хааж байгаа нь гэнэтийн хууль, шийдвэрүүдийг иргэдтэйгээ зөвлөлдөхгүйгээр гаргадаг гэж зуршил тогтсоноос баттай харж болно. Ялангуяа иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд улсын төсвийн орлого үлэмж нэмэгдсэн үеэс төр, төрийн эрхэнд гарсан намууд хаант засагтай нийгмийн хаан шиг, коммунист дэглэмтэй нийгмийн төв хороо, улс төрийн товчоо шиг бүх эрх мэдлийг өөрсдөдөө төвлөрүүлэн алдаатай, алдаагүй элдэв бодлого, шийдвэрээр Монголын нийгмийг сандчаан, тогтворгүй болгож байна. Мөнгө ихтэй, нийгмийн хяналтаас гарсан төр рүү тэмүүлэгсдийн тоо өдөр бүр эгнээгээ тэлж, тэр хэмжээгээр иргэд та бидний эрх мэдэл хумигдаж байна. Тэнд гарч чадсан нь хүүхдийн мөнгө, гэрлэлтийн мөнгө, оюутны мөнгө хуваарилж хуваарилалтын бүлгээс дэмжлэг авч боломжийн бүлгээс элдэв аргаар, заримдаа бүр хүчирхийлж байдгийг нь сорно. Зүйрлэж хэлбэл тулгын гурван чулуу тэнцвэргүй болжээ. Болж бүтэхгүй зүйл гарахаар нэг бол төрөөс төрсөн олигархиуд гэж нэр хайрлаад хөрөнгө мөнгөтэй нэг хэсгийгээ буруутгачихна, эсвэл Монголын баялгийг сорж байгаа гээд гадаадынхныг буруутгачихна. Нөгөө хөрөнгө мөнгөтэйгээр нь эсвэл гадаад дотоодоор нь ялгаварладаг сонгодог арга мөн байгаа биз. Энэ төрийн толгойд гарсан улс төрчдийн ийм сөрөг хандлагыг засаж залруулахгүй бол нэг л өдөр улсын эрх ашиг, төрийн эрх ашиг хэмээх гарт баригддаггүй, нүдэнд үзэгддэггүй зүйлээр хаацайлж нийгмийн хяналтгүй болсон Монголын улс төрчид бидний юуг ч худалдсан байж мэдэх юм шүү. Уг нь 1990 оноос өмнөх монголчуудын туулж ирсэн нийгмийн бүхий л салбарт иргэд нь төрдөө үйлчилж ирсэн бол 1990 оны хувьсгалаас хойш төр нь иргэддээ үйлчилдэг тогтолцоог бид сонгосон билээ. Улсын эрх ашиг гэдэг бол та

бидний эрх ашиг билээ. Төрийн эрх ашиг гэдэг бол иргэдийн эрх ашиг. Иргэнийхээ эрх ашгийг хохироодог, эсвэл зөрчилддөг төрийн эрх ашиг, улсын эрх ашиг гэж байж яавч болохгүй. Төрд Үндсэн хуулиар ногдуулсан үүргийг төр хэрхэн хэрэгжүүлж байгаад та бидний төлөөлөл болгоно гээд сонгосон Их хурал эсвэл Үндсэн хуулийн цэц хяналт тавина хэмээн горьдон суусаар байвал бухын доодхыг харж үнэг турж үхэв гэгч болох нь ээ.

Тулгын гурван чулууны нэг чулуу нь хэт

том болж нөгөө хоёр чулуундаа халтай, дарж унаж магадгүй болжээ. Том төрийг ухаантай төр болгох санаачилга чухамхүү үүнийг хэлээд байгаа бус уу.

Өнөөгийн ярвигтай, хүндхэн нөхцөл байдалд Тулгын гурван чулуу шиг бие биенээ тулж, түшиж байж тулгамдсан асуудлуудаа зөв шийдвэрлэх гарцаа олох юм.

Уг нь иргэн бүр баялаг бүтээгч байж, түүнийхээ үр шимийг хүртэх эрхтэй хэмээн Үндсэн хуулиндаа тусгасан юмсан. ■

WE EXTEND OUR HOSPITALITY TO THE GLOBAL TRAVEL INDUSTRY.

4–8 March 2015 · itb-berlin.com



**БИД ДЭЛХИЙН ХАМГИЙН ТОМ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭНД
МОНГОЛ УЛСЫГ ЧИН СЭТГЭЛЭЭСЭЭ ТАВТАЙ МОРИЛОХЫГ УРЬЖ БАЙНА.**

Сайн байна уу, Монгол Улс,
Монгол Улс нь ИТБ Берлин 2015 аялал жуулчлалын үзэсгэлэнгийн албан ёсны түнш орон ба тэрээр өөрийн хосгүй сайхан газар нутаг түүнчлэн ард түмнээрээ дэлхийг гайхан бишрүүлнэ.

Official Partner Country ITB Berlin 2015

Mongolia
Nomadic by Nature

Messe Berlin

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

“Чингис” бондын зарцуулалт



3 Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох 888 төсөл

Сая төгрөгөөр	Нийт 888 төсөл:	Экспортын төслүүд:	Импортын төслүүд:
Хүссэн санхүүжилт:	4,351.3	1,040.5	3,310.8
Төслийн нийт санхүүжилт:	7,624.4	1,541.1	6,083.4
Шинээр үүсгэх ажлын байрны тоо:	39,951	10,177	29,774
Төсөл өртгөө нөхөх хугацаа /сараар/:	55	52	55

5 Хөрөнгө оруулалтын тойм/ олголт, зээлдэгчээр/

	Эргэн төлөлт ба санхүүжилтийн эх үүсвэр	Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бодлогын хүрээнд	Нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд	Хөдөө орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд	“Чингис Хаан” Боинг В767-300ER онгоцны “гүүрэн” буюу түр санхүүжилт	Нийт
Төсөөс эргэн төлөгдөх	Чингис бондын эх үүсвэр		152.4	369.0		521.4
	Хөгжлийн банкны эх үүсвэр	31.1	158.9	184.5	-	374.5
	Нийт	31.1	311.4	553.4	-	896.0
	Хувиар	3.4%	38.5%	92.5%	0.0%	36.6%
Төслөөс эргэн төлөгдөх	Чингис бондын эх үүсвэр	306.1	307.4	35.3	121.9	770.7
	Хөгжлийн банкны эх үүсвэр	570.9	190.6	9.8	7.1	778.4
	Нийт	877.0	498.0	45.0	129.0	1,549.0
	Хувиар	96.6%	61.5%	7.5%	100.0%	63.4%
Чингис бонд	Нийт	306.1	459.8	404.3	121.9	1292.1
Хөгжлийн банкны эх үүсвэр	Нийт	602.0	349.5	194.3	7.1	1152.9

Б.БАЯРТОГТОХ

Манай сэтгүүл “Баялаг бүтээгч” шинэ буланг энэ сараас хөтлөн явуулахаар боллоо. Энэ булангийн хойморт үндэсний ажил олгогч, үйлдвэрлэгч, компани, аж ахуйн нэгжийн бодлогыг тодорхойлогчид уригдан оролцоно. Хувь хүний амжилт, бизнесийн уналт, сэргэлт, хэтийн төлөв, ирээдүйн боломжийн талаар бид ярилцах юм. “Баялаг бүтээгч” хэн бүхэнд манай сэтгүүлийн булан үргэлж нээлттэй байх болно. Анхны зочноор “Оюуны ундраа” групп-ын Ерөнхий захирал С.Амарсайхан оролцож байна.

Түүний багын мөрөөдөл гадаад харилцааны ажилтан болох. Бизнесийн салбарт амжилттай яваа тэрбээр тэрхүү мөрөөдлөө биелүүлж, Монгол Улсаа төлөөлөн Элчин сайдын яаманд хүртэл томоохон алба хашиж явсан. Мөрөөдөлдөө хүрсэн, төрийн албанд хүч сорьсон энэ эрхэм бизнесийн салбарт эргэлт буцалтгүй орж ирсэн. Үүнийгээ “Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулж явбал илүү үр дүнтэй юм байна” хэмээн тайлбарлах. Ингээд “Баялаг бүтээгч”-ийн ярилцлагад анхаарал хандуулья.



АНУ-ын Лос-Анжелес хотын коллежийг Бизнесийн удирдлага мэргэжлээр төгсч, 1998-2000 онд Соут Вейстерны их сургуульд Эрх зүйн чиглэлээр магистр хамгаалсан.

БАЯЛАГ БҮТЭЭГЧ

С.АМАРСАЙХАН: МОНГОЛ УЛС ХҮЧИРХЭГ ХУВИЙН ХЭВШИЛТЭЙ БОЛНО ГЭДЭГТ ЭРГЭЛЗДЭГГҮЙ

Анхны өнгөт хэвлэлийн үйлдвэрээс бизнесийн гараа эхэлсэн

-Та одоогийн бизнесийн гараагаа анх юунаас эхэлж байсан бэ. Компани байгуулж байсан тэр үед дурсахгүй юу?

“Оюуны ундраа” компани 1992 онд байгуулагдсан Монголын анхны хувийн хэвшлүүдийн нэг. Үүнээс хойш 22 жил өнгөрсөн байна. Бизнес хийх явцад алдаа, одоо бишгүй тохиолддог. Тэр бүхнээс сургамж авч, алдахдаа алдаж, онохдоо онож, үнэнч шударгаар

ажиллаж, зөвийг сэдсэнийхээ төлөө гадуурхагдаж, бурууг хийгээгүйнхээ төлөө зарим нэгэнд гүтгүүлсэн ч шантралгүй өдий хүрчээ. 1992 он бол улсаараа л учраа олох гэж хөдөлж байсан үе. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих үетэй зэрэгцэж бусдын адил бизнесээ эхэлж байлаа. Энэ үед нийгмийн өөрчлөлт, шинэчлэлт эрчимтэй өрнөж байсан цаг. Манай компани анх хэвлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан. Өөрөөр хэлбэл, Монголын анхны өнгөт хэвлэлийн үйлдвэрээс бизнесийн гараа эхэлсэн дээ.

-Ах, дүү нарын дунд хэвлэлийн чиглэлийн хүн байсан байх нь. Тийм үү?

-Отгонбаяр ах маань Москвагийн их сургуулийг Хэвлэлийн инженерийн мэргэжлээр 1989 онд төгсч ирсэн. Удалгүй өөрийн өнгөт хэвлэлийн жижиг үйлдвэр байгуулж бизнесээ эхэлж байв. Тухайн үед “Гутлын 22” гэж байсан. Тэдний подвалд үйлдвэрээ байгуулж байв. Эндээс “Оюуны ундраа” компани үйл ажиллагаагаа эхлүүлсэн түүхтэй. Манайх хойд хөршөөс анх бензин, шатахуун оруулж ирж, зах зээлд нийлүүлэн үйл ажиллагаагаа өргөжүүлж байлаа. ▶



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

Уул уурхайн салбарт сүүлийн 10 гаруй жил ховор металлын хайгуул, олборлолт, ашиглалт, боловсруулалт, экспортын чиглэлээр дагнан ажиллаж буй үндэсний компаниудын нэг. Бид ховор металлыг зөвхөн олборлож, боловсруулаад гаргах бус эцсийн бүтээгдэхүүн болгон гаргах төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

► Өнөөдөр бол олон салбарт ажиллаж байна.

-Танайх нефтийн бүтээгдэхүүний импортод түшиглэсэн анхны хувийн компани юм байна байна шүү дээ.

-Тухайн үед Монголд хамгийн анхны нефтийн бүтээгдэхүүн импортоддог, жижиглэн болон бөөний худалдаа эрхэлдэг хувийн хэвшлийн компани нь манайх байсан. Түүгээр ч зогсохгүй 1995 оноос судалгаа, тооцоо хийж нефть боловсруулах үйлдвэрийн төслийг боловсруулж эхэлсэн. Монгол Улсын дотоодын хэрэгцээг хангах хэмжээний томоохон төслийн техник эдийн засгийн үндэслэл болон

бусад тооцоо, судалгааг бүрэн хийж, хөрөнгө оруулалтаа ч шийдсэн. Үйлдвэрээ 2000 оны эхээр ашиглалтад оруулахаар их хэмжээний хөрөнгө зарцуулсан. Харамсалтай нь тухайн үеийн улс төрийн дарамт шахалт, албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлоос болоод төсөл маань хэрэгжээгүй.

-Тэр үед төр танай төслийг дэмжсэн бол манайх нефтийн бүтээгдэхүүний хараат байдалд орохгүй байж болох байжээ?

-Бид төрөөс ямар ч хөрөнгө мөнгөний тусламж хүсч байгаагүй. Дэмждэггүй юмаа гэхэд хориг саад тавиагүй бол өдийд ямар ч байсан үндэсний газрын тос боловсруулах үйлдвэртэй байх байсан. Хувийн жижиг компани бүтэн таван жилийн турш судалгаа хийж, 250 сая ам.долларын хөрөнгө босгосон байхад төслийн эсрэг шийдвэрийг тухайн үеийн Засгийн газар гаргаж байсан. Хил гаалиар манай компанийн нефтийн тоног төхөөрөмжийг оруулж болохгүй гэсэн шийдвэр хүртэл гарч, бидний ажлыг төрийн нэр зүүсэн нөхдүүд зогсоож байсан гээд бодохоор харамсалтай байдаг юм. Ийм хандлага өнөөгийн нийгэмд ч байна.

-Танай компани одоо ямар чиглэлд үйл ажиллагаа явуулж байна вэ. Үл хөдлөх хөрөнгө, бизнес, уул уурхайд ажилладаг талаар өмнө сонсож байсан. Одоо өөрчлөгдсөн үү. Дахиад шинэ төсөл, шинэ зүйл рүү орохоор төлөвлөж байна уу?

-Шинэ зүйл эхлүүлэхээс илүүтэй одоогийн ажиллаж байгаа салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх, хөгжүүлэхэд илүү анхаарч байна. Өнөөдрийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгө, банк санхүү, мэдээллийн технологи гээд хэд хэдэн чиглэлд 10 гаруй охин болон салбар компанитайгаар үйл ажиллагаа явуулж байна. Тодруулбал, уул уурхайн салбарт сүүлийн 10 гаруй жил ховор металлын хайгуул, олборлолт, ашиглалт, боловсруулалт, экспортын чиглэлээр дагнан ажиллаж буй үндэсний компаниудын нэг. Бид ховор металлыг зөвхөн олборлож, боловсруулаад гаргах бус эцсийн бүтээгдэхүүн болгон гаргах төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

-Группын үнэт зүйл юу вэ. Танайх хэчнээн хүнийг ажлын байраар хангаж байна вэ?

-Манай компанийн үнэт зүйл маш тодорхой байдаг. Улс үндэстнийхээ эрх ашгийг хүндэтгэн бизнесийн ёс зүй, хэм хэмжээг дээдэлж эх орныхоо нийгэм, эдийн засгийн тулгуур салбаруудад манлайлагч байх. Манайх нийтдээ 1500 гаруй хүнийг ажлын байраар хангаж байна.

-“Оюуны ундраа” ямар утгыг бэлгэдэж өгсөн нэр вэ. Үүнийг танай ах, дүү нарын хэн нь өгч байсан талаар сонирхуулаач?

-Миний дээд талын ах шашин соёлын чиглэлээр багаасаа гадаад дотоодод ном үзэж, гүн ухаан судалсан лам хүн байдаг. Тэр ах маань “Оюуны ундраа” нэрийг өгсөн юм. Үргэлж шинийг сэдэж, оюун билэг нь ундарч байг гэсэн утгатай юм. Нийгэм, эдийн засгийн салбарт хэрэгтэй шинэ содон зүйлийг сэдэж, хувь нэмрээ оруулж, оюун бодол нь байнга дэлгэрч яваг гэсэн санааг илэрхийлдэг.

Би захирал учраас бүгдийг мэднэ, шийднэ гэж асуудалд ханддаггүй

-Таны 1500 гаруй хүнийг удирдан чиглүүлж, хамтран ажилладаг арга барил юу вэ?

-Аль болох тухайн ажилтанд бие даан ажиллах боломж олгохыг хичээдэг. Эргээд тэр хэмжээгээр үр дүн гараасай гэж хүсч, хүлээдэг. Үүнийгээ ч ажилтан, албан хаагч нартаа хэлж, ил тод, нээлттэй ярилцдаг. Аливаа байгууллагын хамгийн том хөдөлгөх хүч нь хүн гэдгийг та бид сайн мэднэ. Хамтдаа хөгжиж, дэвших, тэдэнд урам зориг, итгэлийг өгөх, тэр боломжийг бүрдүүлэхийг хувьдаа зорьдог. Түүнээс би захирал, дарга учраас бүгдийг мэднэ, шийднэ гэж асуудалд ханддаггүй. Миний шийдэл зөв ч, буруу ч бай хамтын шийдвэр гаргах зарчмыг чухалчилдаг. Бурууд хатуу, зөвд зөөлөн байх зарчим баримталдаг даа.

-Эрсдэлгүй бизнес гэж байдаггүй. Таны хамгийн том эрсдэл хүлээж байсан бизнес юу байв? ►

▶ -Алдаа оноогүй ажил, амьдрал, эрсдэлгүй бизнес гэж байхгүй. Нөгөөтэйгүүр, эрсдэлгүй бизнес бол бизнес биш ч гэж ярьдаг. Ялангуяа манайх шиг хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын орчин нь тогтвортой бус талбарт бизнесийг эрсдэлгүй удирдана гэдэг тийм ч амар зүйл биш. Шууд хэлэхэд, хууль журмаа мэдэхгүй төрийн ажилтны хүнд суртал, хаалт боолт гээд өдөр бүр бизнес эрсдэлтэй нүүр тулж байна. Бидний учирсан хамгийн том эрсдэл гэвэл дээр дурьдсан маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн нефть боловсруулах үйлдвэрийн төсөл. Сүүлд харилцаа холбооны хамгийн өртөг багатай, хямд мөртлөө чанартай гар утас, интернетийн үйлчилгээг оруулж ирэхээр 30 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн төслийг

маань мөн улс төр, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын шалтгаанаар 2006 онд зогсоосон. Ингээд яриад байвал томоохон эрсдэл, учирсан хохирлууд нэлээдгүй бий. Бидний ажлыг гацаасан эрхмүүд нь нэртэй, устайгаа ч тодорхой байдаг. Одоо ч том, том алба хашаад гэмгүй царайлсан нөхдүүд явж байна.

-Бизнес итгэл, ашиг орлого дээр тогтдог гэдэгтэй та санал нийлэх үү. Эсвэл өөр зүйл дээр оршин тогтдог уу?

-Бизнес ашиг орлого дээр тогтдог гэхээсээ илүүтэй нийгмийн болон хүмүүсийн хэрэгцээ шаардлагад тогтдог гэвэл илүү бодитой байх. Хүмүүс юу хүсч байна, нийгмийн хэрэгцээ шаардлага нь юу вэ гэдгээс хамаарч бизнес оршин тогтнох эсэх нь

шалтгаална. Түүнээс зөвхөн би л ашиг олох ёстой, миний сэдсэн бүхэн илүү ихийг олно гээд явбал тэр бизнес биш дэмий зарлага, дампуурал болно. Цаг үеийн шаардлага, хүмүүсийн хүсэл, хэрэгцээ, ил тод байдал, харилцан итгэлцэл, хүн чанар гэсэн цогц зүйл дээр бизнес оршин тогтнож байдаг.

Баялгийг үнэлдэг сэтгэлгээ урт хугацааны хөгжлийн үндэс

-Бизнесийн өнөөгийн орчин ямар байна вэ. Өмнөхөөс сайжирсан байдал харагдаж байна уу?

-Шуудхан хэлэхэд бүх зүйл сайжрах хөгжихийн эсрэг зүг байна. Хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын найдвартай бөгөөд таатай орчин энэ улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн хамгийн чухал суурь байх ёстой. Харамсалтай нь хүссэн хэмжээнд дээрх асуудал хөндөгдөж, шийдэгдэж чадахгүй байна. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монголын хувийн хэвшлийнхний бий болгосон нийгмийн баялаг, хөрөнгө оруулалтын орчин, зах зээлийн хөгжил, тэдгээрийн үнэ цэнэ, үнэт зүйлүүд сүүлийн жил хагасын хугацаанд үндсэндээ үгүй боллоо.

Шуудхан хэлэхэд бүх зүйл сайжрах хөгжихийн эсрэг зүг байна. Хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын найдвартай бөгөөд таатай орчин энэ улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн хамгийн чухал суурь байх ёстой. Харамсалтай нь хүссэн хэмжээнд дээрх асуудал хөндөгдөж, шийдэгдэж чадахгүй байна.

-Танай компанийн үйл ажиллагаанд өнөөгийн эдийн засгийн хүндрэл хэрхэн нөлөөлж байна вэ. Үүнээс гарах ямар стратеги төлөвлөгөөг боловсруулсан бэ? »



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

► -Зөвхөн компани гэлтгүйгээр айл өрхийн аж амьдралд өнөөгийн эдийн засгийн хүндрэл хүчтэй нөлөөлж байна. Бид зөвхөн нөлөөлж байна гээд яриад өнгөрөх бус цаашид ямар арга хэмжээ авах талаар дор бүрнээ тунгаан бодож, төлөвлөх шаардлага тулгарч байна. Засаг төрөөс дорвитой арга хэмжээ авч, хямралыг бага хохиролтой туулахын тулд илүү сайн ажиллах ёстой. Манай компани зарим үйл ажиллагааг хооронд нь уялдуулах, зохион байгуулалтыг шинээр хийх, шаардлагагүй зардал, хөрөнгө оруулалтыг түр хугацаанд зогсоох байдлаар арга хэмжээ авч байна.

Хувийн хэвшлийг хөгжлийн хөдөлгүүр гэж ойлгодог улстөрчид үгүйлэгдэж байна

-Хэдий эдийн засаг хүнд, нийгэм бүхимдалтай байгаа ч хүмүүс ирээдүйдээ найдах итгэлээ алдаагүй. Монгол Улсын дунд болон урт хугацааны хөгжлийг та хэрхэн төсөөлж байна вэ?

-Миний хувьд Монгол Улсын хэтийн хөгжлийг маш өөдрөгөөр төсөөлдөг. Богино хугацаанд олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц чадвартай, оюунлаг иргэдтэй, үндэстэн дамнасан Монгол компаниуд бий болох асар их нөөц байна. Монгол Улс хүчирхэг хувийн хэвшилтэй болно гэдэгт эргэлздэггүй. Цаашлаад Монгол бүс нутагтаа төдийгүй дэлхийн улс төр, эдийн засгийн бодлогод чухал байр суурь эзлэх нөлөө бүхий улс байх бодит нөхцөл, боломж ч бий. Энэхүү боломжоо хэрхэн зөв зүйтэй ашиглах вэ гэх арга замаа зөв тодорхойлж чадахгүй цаг алдлаа. Үндэсний хөгжлийн нэгдсэн стратеги, төлөвлөлт, улс төр, эдийн засгийн дипломат харилцааны урт хугацааны нэгдсэн стратеги чухал. Гэтэл ийм тогтвортой бодлогогүйгээр өнөөг хүртэл явж ирсний нэг илрэл нь одоогийн эдийн засаг, зах зээлийн хүндрэл юм.

Хөгжлийн бодлого, төсөл хөтөлбөр боловсруулахдаа баялаг бүтээгч, эрдэмтэн судлаач, мэргэжлийн судалгаа, шинжилгээний байгууллагуудын бодит тооцоо, судалгааг тусгадаггүй. Тэдний санал

оролцоогүйгээр, зөвхөн сэтгэлийн хөөрөл, бодит бус төсөөллөөр үйлдэж, үүнийгээ хэрэгжүүлэх гэж муйхраар зүтгэлээ. Өөрөөр хэлбэл, баялаг бүтээгч, эрдэмтэн судлаачдаа үнэлж, хүндэлж чадахгүйгээс хөгжил гэдэг зүйл эргээд 20 жилийн өмнөх үе рүү унах хэмжээнд доройтлоо. Тиймээс Монгол Улсын хөгжилд баялаг бүтээгчдийн хувь нэмэр чухал болохыг ойлгох, тэдний зүтгэл, дадлага туршлагыг хүссэн хүсээгүй ашиглах нь үр дүнтэй гэдгийг цаг үе харуулж байна.

-Улс орны тогтвортой хөгжлийн үндэс суурийг бий болгох бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга зам нь юу юм бол ?

-Манайх хүн ам цөөтэй, далайд гарцгүй ч асар их боломжтой улс. Уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, газрын тос, хий гээд хэлээд байвал их олон сонголт, боломж дунд бид амьдарч байна. Энэ бүхэн бидний боломж, Монголын ирээдүйн хөгжил гэж харж байна. Гагцхүү төрийн бодлого ямар байхаас л шалтгаална. Өнгөрсөн хугацаанд улс орны эдийн засгийн бодлого, төлөвлөлт, хэрэгжүүлэлтийг зөвхөн улс төрчид, улс төрийн намууд дангаараа тодорхойлж, гардаж ирсэн нь том алдаа гэдгийг дээр дурьдсан.

Цаашдын тогтвортой хөгжлийн үндэс суурийг бий болгохын тулд “Үндэсний эдийн засгийн бодлого төлөвлөлтийн институт” гэдэг бие даасан, хараат бус бүтцийг нэн даруй бий болгох ёстой. Энэ байгууллагын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг хуульчилж, албан ёсоор байгуулах хэрэгтэй. Ингэснээр улс орны эдийн засгийн хөгжилтэй холбоотой аливаа хууль, тогтоомж, бодлого шийдвэрийг төрөөс гаргахдаа зөвхөн энэ байгууллага судалгаа, тооцоо, зөвлөмж, зөвлөгөө гаргадаг, түүнийг нь үндэслэн олон нийтийн дунд хэлэлцүүлэг хийдэг болох учиртай. Хамгийн сүүлд нь Засгийн газар, УИХ-аар дээрх бодлогын баримт бичгээ оруулж хэлэлцүүлж батлуулдаг болчихвол бодлогогүй, тооцоогүй хууль санаачилж баталдаг улстөрчдийн эрсдэлтэй тоглоомоос улс орны эдийн засгийн хөгжил ангид урагшлах юм. Энэ талаар бид өнгөрсөн хоёр жилийн

хугацаанд төр засаг, улс төрийн намуудад олон удаа санал тавьж байсан.

-Баялаг бүтээгчдээ дэмжих тал дээр манайх нэлээд хойрго ханддаг. Гэтэл Азийн үсрэнгүй хөгжилтэй орнууд баялаг бүтээгч дээрээ тулгуурлаж хөгжсөн байдаг.

-Байгалийн баялгаас гадна тодорхой хэмжээнд нийгмийн баялаг бүтээж буй хүмүүсээ үнэлж байж хөгждөг бичигдээгүй хуультай. Гэтэл манайд баялаг бүтээгчдээ үгүйсгэж, ад үзсэн хэрнээ хийсэн талхыг нь идэж, барьсан байранд нь амьдарч, бий болгосон үйлчилгээний газраар нь үйлчлүүлж, ажил амьдралаа залгуулсаар л байдаг. Сүүлийн үед баялгийг үнэгүйдүүлэх хандлага газар авсаар байна. Нийгэмд бий болж буй зам харгуй, барилга, бүтээн байгуулалт бүгд нийгмийн баялаг. Хэдий зарим нь хувь хүний өмч гэж байгаа ч тэр бүгд нийгмийн баялаг болж үлддэг, нийгмийн хэрэгцээнд ашиглагддаг. Тэр баялгийг үнэлж хөгждөг сэтгэлгээ, зарчим урт хугацааны хөгжлийн үндэс.

Бидний тийм л болох юмсан гэж мөрөөдөөд байдаг гаднын орны жишигтэй харьцуулаад үзье. Хувийн хэвшлээ хүндэлж, эрдэмтэн судлаачдаа дээдэлж, баялгийг үнэлж, төр нь бодлоготойгоо ойр байсан улсууд өнөөдөр илүү хөгжиж чадаж байна. Үүний амьд жишээ нь Япон, Сингапур, Өмнөд Солонгос. Цаашилбал, Америк, Европт ийм л зарчим үйлчилж байна. Бизнес эрхлэх хамгийн таатай орчин дээрх орнуудад улам бэхжиж байна. Хувийн хэвшлийг хөгжлийн хөдөлгүүр, нийгмийн баялаг гэж ойлгодог засаглал, улстөрчид үгүйлэгдэж байна.

Бизнес эрхлэгчид цаг нартай уралдах гэж хичээж байхад...

-Танай компанийн өнөөдрийн амжилтын нууц вэ?

-Нэг их нууцлаад байх зүйл юу байх билээ. Бусдын л жишгээр хөдөлмөрлөж байна. Хийх ажил, бүтээх зүйл их байх юм. Бизнес эрхлэгчид цаг нартай уралдах гэж ►►

► хичээж байхад шийдвэр гаргагчид шилээ татаж, хүнд суртал гарган улс орны хөгжил, хүмүүсийн амьдралыг хойш татаад байдаг гол харладаг. Аливаа саад бэрхшээлээс шантрахгүй, өөрсдийн үзэл бодол, үнэт зүйлдээ тууштай байж, алдаж, онож явсны үр дүнд урагшилж явна.

-Та багын найзуудтайгаа хэр холбоотой байдаг вэ. Хүн өөрөө ч мэдээгүй байхад бусдад өөрчлөгдсөн мэт санагдах нь бий. Таныг мөнгө өөрчилсөн болов уу?

Эрх мэдэл, албан тушаал, өнгө мөнгө, эд хөрөнгө хүний амьдралд ирдэг явдаг зүйл гэж хүлээж авдаг. Тэр утгаараа хөрөнгө мөнгийг хэт шүтээд, бусдыг умартаж, үгүйсгэж явбал амьдрал өөрөө утга учиргүй, хүний мөн чанар гэж байхгүй болно.

-Мөнгө миний ажил, амьдралыг өөрчилж болно. Гэхдээ миний хувь хүний мөн чанар, үзэл бодлыг өөрчлөхгүй. Тодорхой хугацаанд их бага хэмжээний хөрөнгө, мөнгөтэй харилцах явцад өөрийгөө хэн бэ гэдгээ таниж чадсан гэж би хувьдаа ойлгодог. Багын найз нар бий. Тэдэнтэйгээ байнга холбоотой, жаргал, зовлонгоо хуваалцаад явдаг. Эрх мэдэл, албан тушаал, өнгө мөнгө, эд хөрөнгө хүний амьдралд ирдэг явдаг зүйл гэж хүлээж авдаг. Тэр утгаараа хөрөнгө мөнгийг хэт шүтээд, бусдыг умартаж, үгүйсгэж явбал амьдрал өөрөө утга учиргүй, хүний мөн чанар гэж байхгүй болно. Мэдээж хүн бүр сайхан амьдрахад мөнгө тодорхой байр суурийг эзлэх нь ойлгомжтой. Гэхдээ мөнгө бидний хэрэгцээ, хийж бүтээхэд шаардлагатай шийдлийн нэг хэсэг болохоос түүнийг ухаангүй шүтэж, бүх зүйлийн хэмжүүр болгон амьдрах нь утгагүй.

-Та шүүмж болон магтаалыг өөртөө хэрхэн хүлээж авдаг вэ?

-Ажил амьдралаа зөв авч явахад эрүүл шүүмжлэл хүн бүрт хамгийн чухал.

Ажил хэрэгч зарчимтай шаардлагыг хүн тавиасай гэж хүсдэг ч гэж хэлж болно. Анд нөхрийн, ажил хэргийн шугамаар хандаж байгаа шүүмжлэлийг илүү хүлээн авдаг. Миний үйл хөдлөл бусдад таалагдахгүй, эрх ашгийг нь хөндөж байвал надад нээлттэй шууд ил хэлээсэй гэж боддог. Хүмүүст ч гэсэн би хэлье гэсэн зүйлээ нөхөр болоод найзын хувиар, ажил хэргийн шугамаар зарчмын зүйлүүдээ хаана ч байх ёстой зохих түвшинд нь илэрхийлэхийг боддог. Харин магтаал хүлээж авахдаа жаахан тааруухан. Магтаалд хөөрөөд дэвээд байдаггүй. Өөрөө өөртөө цаг үеийн бодитой дүгнэлт өгч, магтаал, шүүмжлэлийн дундаас өөрийнхөө үнэн төрхийг олж, мэдэрч амьдрахыг хичээж явдаг.

-Та одоо ямар ном уншиж байна байна вэ?

-“Ажил хэрэгч хүмүүсийн долоон зарчим” гэсэн ном уншиж байна. Болж өгвөл шинэ зүйл уншиж өөрийн оюуныг сэргээж байхыг хичээдэг. Даан ч тэр болгон ном барьж амжихгүй юм. Үүний өмнө Монголын агуу хатдын нэг болох “Сорхугтан” хатны тухай роман уншсан.

-Таны хувь хүний төлөвшилд гэр бүлээс олгосон хүмүүжил болон хамгийн их нөлөө үзүүлсэн хүчин зүйл юу бол?

-Хэд хэдэн чухал зүйл байдаг. Эхнийх нь эцэг, эхээс үлгэрлэсэн суурь хүмүүжил. Аав ээж минь бидэнд өв хөрөнгө бус өөрийн гэсэн хувь хүний үзэл бодол, үнэт зүйл, түүндээ тууштай байх зарчмыг өвлүүлж үлдээсэн. Хүүхдүүдээ зөв хүн болгохын төлөө бие сэтгэлээ зориулсан хүмүүс. Би зургаан ах, нэг эгчтэй. Ах, эгч нар ч аливаад хатуурхаад байдаггүй. Аядуу зөөлнөөр дэмжиж, хөгжүүлэхэд санаа тавьж хүмүүжүүлсэн. Бид нийгэмд эзлэх байр суурь, хувь хүний ажил хэрэг, амьдралын сонголтод үзэл бодол зөрчилдөх зүйлүүд байдаг ч бие биесээ хүндэтгэн хайрлах, хүн ёс хийгээд аав ээжээс бэлэглэсэн ах дүүгийн нандин холбоогоо үргэлж дээдэлж, ухамсарладаг. Эдгээр нь намайг хурц үед зөөллөж, мохсон үед минь ирлэж явдаг юм. Мөн миний тодорхой хугацаанд гадаадад сурч, ажиллаж амьдарч байхдаа олж авсан бага ч болов дадлага, туршлага маань

өнөөгийн хувь хүний төлөвшилд чухал байр суурь эзэлдэг.

-Та бизнесийг юутай зүйрлэдэг вэ. Зарим хүмүүс уран барилга, сийлбэртэй адилтгасан байдаг юм билээ .

-Бизнес заримдаа хөлгүй далайд моторгүй завиар аялах мэт эрсдэлтэй ч сонсох тусам татагддаг хөгжим, мэдрэх тусам эрч хүч авдаг энерги, услах тусам ургадаг цэцэгтэй адилхан зүйл. ■

ХӨРШ

АЛТАН ҮЕ

Б.ТОГТОХ

Аливаа улсын эдийн засгийг дундаж давхарга нь хөтөлдөг. Дундаж давхаргагүй эдийн засаг урт хугацаанд оршин тогтнох боломжгүй. Тиймээс дэлхийн улс орнууд эдийн засгийн ►



▶ тогтвортой хөгжилд хүрэхийн тулд тэргүүн ээлжинд суурь давхаргаа бэхжүүлсэн байдаг. Ингэснээр хөгжил нь хөл дээрээ бүрэн зогсож, үндэсний эдийн засаг сэргэдэг. Үүний жишгээр яваа орны нэг нь БНХАУ. Бээжинд суугаа тус улсын дарга Си Зиньпин дундаж давхаргаа тэлэх гэж эдийн засгийн бодлогоо эргэн харж, бүтцийн өөрчлөлт хийж байна. Үр дүнд нь Хятад орон гаднын хэрэглэгч зах зээлээс үл хамаарч, өөрсдийн хүчинд бүрэн найдах хэмжээнд “бяр суух” явдал. Энэ бол их гүрний бодлогын зураглал.

БНХАУ-ын нийгмийн шинжлэх ухааны академийн судалгаагаар тус улсын дундаж давхарга нийт хүн амынх нь 23.5 хувьтай тэнцэж байна. Энэ нь ойролцоогоор 300 гаруй сая бөгөөд тэд жил бүр эгнээгээ 1.5 хувиар эрчтэй тэлж байгааг дээрх судалгааны тайланд онцолжээ. Хятадын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 30 жилийн өмнө дөнгөж 250 ам.доллар байсан. Тэгвэл өнөөдөр 6.5 мянган ам.доллар болтлоо өссөн байна.

Юанийн худалдан авах чадварыг илтгэх инфляци нь сүүлийн таван жилийн хугацаанд 2-4 хувийн хооронд хэлбэлзэх бөгөөд харьцангуй тогтвортой явж иржээ. БНХАУ тансаг

эд барааны хэрэглээгээр АНУ-ыг 2009 онд давж, дэлхийн 25 хувийг эзлэн удаалж явна. Улам бүр олширч буй барууны брэндийн компаниуд худалдааны агентуудаа ашиглахаас татгалзаж, Хятадын зах зээлд шууд борлуулалт хийх нь түгээмэл үзэгдэл болсон. Хятадыг нийгмийн бүтээгдэхүүн худалдан авах чадвараар авч үзвэл АНУ-ыг ирэх онд түрэн гарахаар буй.

Дэлхийн эдийн засгийн өсөлтөд томоохон үүрэг гүйцэтгэх тус улсад хотжилт эрчимтэй явагдаж, шилжилт хөдөлгөөн хурдсах болсныг дараах тооноос харж болно. Өнгөрсөн 30 хүрэхгүй жилийн хугацаанд хөдөөнөөс Хятадын хотуудад 300 гаруй сая хүн шилжин ирсэн байна. Ирэх 15 жилийн хугацаанд дээрх тоо өсөх бөгөөд дахиад 350 сая хүн нэмж “хотжих” нь. “30 жилийн өмнө Хятадын нийт хүн амынх нь 20 хүрэхгүй хувь хотод амьдардаг байсан бол 2030 он гэхэд хотод амьдрах хүний тоо нэг тэрбумд хүрнэ гэсэн судалгаа гарсан” хэмээн Эдийн засагч Б.Дөлгөөн тэмдэглэн хэллээ.

Хятад эдийн засгийн хувьд улам хүчирхэгжиж, амжилт өөд “шунаж” байна. Энэ эрчээрээ явбал 2020 он гэхэд АНУ-ын өмнө эдийн засгийн тугаа мандуулан 1998 оны улс төрийн

товчооны түүхэн зорилтоо биелүүлэх боломжтой. Энэ үед юань олон улсын валютын үүргийг гүйцэтгэх эсэх асуудал хөндөгдөж мэдэх юм. Одоогийн байдлаар дэлхийн нийт дундаж давхаргын 50 хувийг Ази тивийнхэн бүрдүүлж байгаа. Энэ тоо ирэх 10 жилийн хугацаанд 60 хувьд хүрэх аж.

Хятад бол даян дэлхийн үйлдвэрлэлийн төв. Тус улс дэлхий нийтэд зориулж бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Үүнийхээ 55 хувьд нь нэмүү өртөг шингээж ирсэн. Тэгвэл ирэх жилүүдэд Хятадын зөвхөн дундаж давхаргыг онилж дэлхийн үйлдвэрлэгч бусад орон өөр хоорондоо өрсөлдөх нь.

Хятадын өөрчлөлт, шинэчлэлийн бодлого 30-хан настай. Энэ хугацаанд 1.3 тэрбум хүний амьжиргааны түвшин дээшилж, улсаараа хөгжлийн огцом үсрэлт хийсэн нь дэлхий нийтийг алмайруулж орхисон. Харвардын их сургуулийн Зүүн Азийн эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн захирал Двайт Перкинс “Хятадын дундаж агаар өсөлт хурдацтай байгаа агаад 2020 он гэхэд 700 саяад хүрнэ. Тэдний жилийн орлого энэ үед ойролцоогоор 80-120 мянган юань байна” хэмээсэн.

Дэлхийн хоёр дахь том эдийн засаг энэ оны гуравдугаар улиралд 7.3 хувиар өссөн талаар тус улсын төр захиргааны газраас олон нийтэд мэдэгдсэн. Хэдий эдийн засгийн гялалзсан амжилт энэ онд ялимгүй саарах боловч БНХАУ дундаж давхаргаа бэхжүүлэх бодлогоо хамгаалж үлдэх нь тодорхой. Тэд үүний төлөө алхам ч ухрахгүй.

УИХ-ын гишүүн М.Батчимэг “Хятадын дундаж анги өнөөгийн түвшинд Франц, Германы хүн амаас ч их байна. Гэтэл эдгээр орны эдийн засаг ямар том билээ” хэмээн өгүүлсэн удаатай. Манай гарагийн таван хүн тутмын нэг нь Хятадад амьдардаг. Тэд санхүүгийн эрх чөлөөнд хүрч, мөнгөжих тусам дэлхийг “худалдан авч” мэднэ. Хятадын дундаж ангийн хүний тоо АНУ-ын нийт хүн амаас ялимгүй илүү гарсан. Ингээд зогсохгүй хэрэглэгчдийн нүсэр арми тэнд бий болж байна. Хятадууд үүнийг “Алтан үе” гэж нэрлээд байгаа. ■

Хятадын өөрчлөлт, шинэчлэлийн бодлого 30-хан настай. Энэ хугацаанд 1.3 тэрбум хүний амьжиргааны түвшин дээшилж, улсаараа хөгжлийн огцом үсрэлт хийсэн нь дэлхий нийтийг алмайруулж орхисон.

